

Улсын бүртгэлийн дугаар:

Нууцлалын зэрэглэл: Б

Аравтын бүрэн

Төсөл хэрэгжүүлэх гэрээний дугаар:

ангиллын код

ШүГх/ОХУ/-2018/23

СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛИЙН СОЁЛ УРЛАГ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

**МОНГОЛ, ОРОС, ХЯТАД ГУРВАН УЛСЫН БУРИАД УГСААТНЫ
АМАН СОЁЛ, УГСААТНЫ СОЁЛЫН ХАДГАЛАЛТ,
ХУВИРАЛТЫН СУДАЛГАА**

сэдэвт гадаадтай хамтарсан төслийн эцсийн тайлан

2018-2020

Төслийн удирдагч:

Д.Наранцэцэг доктор (Ph.D), профессор

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Сурвалж бичиг, төвөд
судлалын салбарын эрхлэгч

Захиалагч байгууллага:

Боловсрол, Шинжлэх Ухааны Яам

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан технологийн сан

Тайлан өмчлөгч:

СУИС, Соёл урлаг судлалын хүрээлэн

Чингилтэй дүүрэг, 6-р хороо, СУИС-ийн хичээлийн төв байр,
70137055

УЛААНБААТАР

2022 ОН

Гарчиг

Реферат.....	3
Төслийн зорилго.....	7
Төслийн үр дүнгийн даалгавар.....	8
Төслийн календарьчилсан төлөвлөгөө, түүний биелэлт.....	9
Төслийн гүйцэтгэгчдийн танилцуулга, төслөөр гүйцэтгэсэн ажлын жагсаалт.....	12
Төслийн судлагдсан байдал.....	21
Төсөл хэрэгжүүлсэн байдал.....	24
Томилолтоор ажилласан байдал.....	35
Дүгнэлт.....	48
Талархал	50
Хавсралт 1. Төслийн үр дүнд гарсан бүтээлийн жагсаалт.....	51
Хавсралт 2. СУСХ-ийн Эрдмийн зөвлөлийн тогтоол, хурлын протокол.....	56
Хавсралт 3. ОХУ-ын хамтран гүйцэтгэгч байгууллагын тодорхойлолт, Оросын талын төслийн тайлан.....	61

РЕФЕРАТ

***Төслийн нэр:* Орос, Монгол, Хятад гурван улсын буриад угсаатны аман зохиол, аман соёл, угсаатны соёлыг хадгалалт, хувиралтын судалгаа**

Сохранность и трансформация фольклорных и этнокультурных традиций бурят России, Монголий и Китая

Integrity and transformation of folklore and ethnocultural traditions of the Buryats of Russia, Mongolia and China

Монгол Орос хоёр улсын хамтарсан төслийн хүрээнд 2018-2020 оны хооронд ОХУ-ын Буриад улс, Монгол Улсын Дорнод, Хэнтий, Булган, Хөвсгөл аймгийн буриад угсаатнууд, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орны Шинэхээний буриад угсаатны дунд хийсэн судалгааны ажлын үр дүнг энд авч үзнэ.

Бидний хийсэн судалгаа нь буриад угсаатны биет бус соёлын (шашин шүтлэг, аман соёл) хувирал өөрчлөлт, буриад угсаатны биет (хувцас эдлэл хэрэглэл, сурын харваа) соёлын хувирал өөрчлөлт гэсэн ерөнхий ангилалд хуваагдах бөгөөд төслийн багт Монголын талаас утга зохиол судлаач хэл бичгийн ухааны доктор М. Одмандах, Д. Наранцэцэг, түүхч угсаатны зүйч О. Баттуяа, Л. Оюунцэцэг нар, Оросын талаас Е. В. Сундуева, Х. Б. Цыбикова, Д. С. Жамсуева нарын хэл шинжлэл, түүх, угсаатан судлалын мэргэжлийн эрдэмтэд баг болон ажиллаж байна. Төсөл хэрэгжүүлэх хугацаанд ОХУ-ын Буриад Улсын Улаан-Үд хот, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Шинэхээний буриадууд, Монгол Улсын Булган аймгийн Тэшиг сум, Дорнод аймгийн буриад сумд, Хэнтий аймгийн буриад сумдын нутгаар томилолтоор ажиллаж, судалгааны эх хэрэглэгдэхүүн цуглуулж, дараах чиглэлээр судалгаа хийлээ.

Хэл аялгууны хадгалалт, хувиралтыг судалсан нь

Буриад угсаатны хэл аялгууны байдлаа хэрхэн хадгалж байгааг судлахын тулд 2018 онд төслийн багийнхан хорьдугаар зуунд судлаачдын хийсэн хээрийн шинжилгээний ангийн тайлан, хэвлэгдсэн мэдээ материалтай танилцах, анализ дүгнэлт хийхэд анхаарч ажилласан бол 2019- 2020 онд өнөөгийн буриад угсаатны төлөөлөлтэй уулзан, ярилцлага сурвалжлага авах ажлыг голчлон хийв. Үүнд доктор М. Одмандах Буриад судлалын нэрт эрдэмтэн асан Г.Гантогтохтой биечлэн ярилцаж, түүний цуглуулсан аман зохиолын эх хэрэглэгдэхүүн, гар бичмэлтэй танилцаж, зарим ховор гар бичмэлийг судалгааны эргэлтэд оруулахаар авав. Түүнчлэн ШУА-ийн ХЗХ-ийн сан хөмрөгөөс зарим мэдээллийг үзэж, хуулбар хийж авав. Тус сан хөмрөгөөс бидний судалж буй сэдэвтэй холбоотой зарим мэдээллийг нягтлан магадлаж, харьцуулж үзсэн болно.

Хээрийн судалгааны ажлын үед М.Одмандах, Л.Оюунцэцэг нар Монгол Улсын газар газрын буриадуудын төлөөлөл, өндөр настангууд, ОХУ-ын Түнхэн аймгийн буриадуудтай уулзаж, аман зохиол, ардын дуу, хуур, үндэсний спорт, сурын харваа зэрэгтэй холбоотой мэдээлэл цуглуулж ажиллав. Зарим нэр бүхий хүнээс эртний дуу, дууны үгийг бичиж, аялгууг сонсож, тэмдэглэл хийв.

Мөн ОХУ-ын төслийн багтай хамтарсан хээрийн шинжилгээний ангиар Булган аймгийн Тэшиг суманд ажиллах үед судлаач Дарима, Бадма-Ханда, М.Одмандах, Л.Оюунцэцэг нар орон нутгийн ахмад настан 10 гаруй хүнтэй уулзаж, аман мэдээлэл цуглуулж, зураг, бичлэг хийж авсан бөгөөд уг мэдээлэлд түшиглэн эрдэм шинжилгээний өгүүлэл хамтран бичиж хэвлүүлэв.

БНХАУ-ын Шинэхээний буриаддуудын буриад хэл аялгуугаа хэрхэн сурч уламжилж байгаа байдлын талаар доктор Д.Наранцэцэг Хөлөнбуйр дээд сургуулийн багш, хэл бичгийн ухааны магистр Толон, ОХУ-ын Москвагийн Хэл шинжлэлийн их сургуулийн багш, доктор Д. Василева нарын хамт Шинэхээн сумын бага сургуулийн заан сургалтын байдалтай танилцан, ярилцлага, сурвалжлага хийв. Мөн ОХУ-ын Шинжлэх ухааны академийн Дорно дахин судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудтай хамтран Хөвсгөлийн Цаатны дунд хээрийн шинжилгээний ангиар явах дашрамд Монгол Улсын Булган, Хөвсгөл аймгийн нутагт суурьших буриадаас балчир насандаа нүүж ирсэн Сэлэнгийн Хушаатын шарнууд овогтой Дэмбэрэлийн Байгалмаа, Хөвсгөлийн Балжир бөө зэрэг ахмад настнуудтай уулзан, тэдний бага залуудаа сурсан дуу, хэлц үг, үлгэр түүхийг яриулж, тэмдэглэж авав.

Шашин шүтлэгийн уламжлал, өнөөгийн байдлыг судалсан нь

Буриаддуудын дунд уламжлан ирсэн бөөгийн шүтлэг, бөө мөргөлөөс буддын шашин шүтэх болсон тухайд доктор О.Баттуяа судалж, Монгол улсын Үндэсний төв архивын 92, 101, 102, 132-р сан хөмрөгөөс судалгаанд холбогдох баримт, Монгол улсын номын сангаас буриадын түүх, угсаатны зүйн болон XIX- XX зууны зааг үеийн буриадын аж төрөл, хүн амын шашин шүтлэг, боловсрол мэдлэгт холбогдох тоо баримт, мэдээ мэдээлэл цуглуулан, хэд хэдэн судалгааны өгүүлэл хэвлүүлээд байна. Тухайлбал, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Будда, Төвөд, Монгол судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Д.С.Жамсуевагийн хамт “Оросын нөлөөн доорх буриаддуудын газар эзэмшил ба угсаатны үйл явц” өгүүлэл бичиж “Монголын соёл урлаг судлал” сэтгүүлд хэвлүүлэв. Буриадын уугуул аж ахуй, мөн соёлын зарим өөрчлөлт хувирлын талаарх энэ өгүүллийг өмнө онд хэвлүүлсэн Байгал тойрон нутаглаж байсан буриаддуудын шашин мөргөл нь хаант Оросын бодлого нөлөөгөөр хэрхэн замнаж ирснийг харуулахыг хичээсэн “Буриадын шашин мөргөлийн уламжлалын асуудалд” өгүүлэлтэй уялдуулж бичжээ. “Буриадын шашин мөргөлийн уламжлалын асуудалд” өгүүлэлд Оросын нөлөөн дээх буриадын шашин мөргөлийн асуудлыг хөндсөн бол энд аж ахуйн асуудлыг онцолсон байна. Эртнээс нааш нүүдэлч малчин байсан буриад-монголчууд Оросын мэдэлд хамжигдсанаар ахуй соёлын зарим талаар тэдэнд уусан шингээд эдүгээ нэг хэсэг нь “оросын буриад” гэж үзэгдэн уг удам нэгт монголчуудтайгаа ижилсэх юмгүй шахуу болохдоо хүрээд байгаа бол ХХ зууны эхэн хэрд Монголд ирсэн буриаддууд нь Оросоос тасарч ирсэн, оросын нэг хэсэг мэт үзэгдэх нь ч байна. Тус өгүүлэлд буриадыг ингэж үзэхэд хүргэсэн бусдын соёлын нөлөө, тэр нөлөөллийн түүх яаж эхэлсэн бэ?, түүнээс улбаатай газар эзэмшлийн асуудал, угсаатны үйл явц хэрхэн өрнөсөн бэ? энэ сэдвийг хөндөж түүхчилж бичив. Буриадын аж ахуй, соёлын үйл явц нь оросууд Монголын

түшмэг хараат нутаг байсан Сибирийг эзэлж авсан түүхтэй ямагт холбоотой өрнөсөн байдаг. Иймээс нийт буриадын түүх, угсаатны зүйн судалгаанд, Монголын буриадын судалгаанд ч ялгаагүй энэ үеийг сөхөх хангалттай шалтгаан холбогдол байна гэсэн үг. Үүнийг анхаарч Монголын буриадын аж төрөлд оросын соёл тусгалаа олсон үйл явцыг оросууд өвөр Байгалд ирсэн ХҮИ зууны үеэс эхлүүлэв. Өнгөрсөнд өрнөсөн үйл явцыг зураглан сэргээхэд сурвалжийн мэдээ хамгийн том үүрэг гүйцэтгэдэг. XIX зууны буриадын түүхийн сурвалжийн мэдээг голлон ашиглалаа. Ямар ч ард түмний аж ахуй, соёл нь тэдний туулж өнгөрүүлсэн түүхэн замналтай салшгүй холбогдохын хамт нийгмийн хөгжлийг дагасан шинжтэй хувирч өөрчлөгдөж сайжран хөгждөг жамтай. Ойр дөт хаяа хөрш нутаглаж буй ард түмэн ямар нэг хэлбэрээр соёлын солилцоонд орж бие биентэйгээ ахуй соёлын талаар адилсах нь зүй ёсных боловч тэр үйл явц нь сөрөг ба эерэг шинжтэй, тэрхүү соёлыг хүлээн зөвшөөрч тусган авах нь ч хоёрдмол үр дагавартай. Буриадын оросуудтай адилсах үйл явц мөн ийм замыг туулсан болохыг тоймлон бичжээ.

Буриадын шашин соёлын хөгжлийн түүх нь ХҮИ-XX зуунд өвөр Байгал болон Монголд өрнөсөн улс төрийн үйл явцтай шууд холбогдоно. Оросууд өвөр Байгалын оршин суугчдыг соёлын хувьд уусгах гэсэн бодлогоо бөө мөргөлийг хүчгүйдүүлж, үгүй болгох замаар эхлүүлжээ. Үүнийгээ лам нарыг олшруулж, шарын шашиныг дэмжих замаар хэрэгжүүлж байв. Оросын энэ бодлого нь бурхны шашиныг хөгжүүлж бөө мөргөлийг хүчгүйдүүлэхийг зорьж байсан тул дорнын нэг соёлыг нөгөөгийнх нь эсрэг ашиглан, буриадын шашин мөргөлийн хөгжилд ихээхэн өөрчлөлт авчиржээ. Гэсэн ч өнөө хэр нь буриадууд бөө мөргөлийн уламжлалаа гэр орныхоо орчинд хадгалсаар иржээ. Өөрөөр хэлбэл буриадуудын дунд бөө мөргөл, бурхны шашны ёс уламжлал зэрэгцэн оршиж байна гэж манай судлаач дүгнэсэн юм.

Угсаатны соёлын хадгалалт, хувиралтыг судалсан нь

Монгол Улс дахь буриад угсаатнуудын дунд үндэсний спортын төрөл зүйлүүдийн хөгжилт, хандлага ямар байгааг доктор М. Одмандах судалж, ажиглалт хийв. Эртний монгол язгуурын аймгийн нэгэн буриадын Хонгоодор овгийн буриад нарын нутаглаж байгаа Тэшигийн Зэд нурууны ар, Тэшигийн давааны ар Эрэнгийн голоор нутаглаж байгаа буриад айл өрхийн аж амьдрал, ахуй байдлын талаар мэдээлэл цуглуулж, гэрэл зургаар баримтжуулан хадгалав.

Булган аймгийн Тэшиг суманд аж төрөн амьдрах буриадууд нь сумынхаа хүн амын 25%-ийг эзлэх бөгөөд голчлон Зэдийн нурууны ар, Тэшигийн давааны ар Эрэнгийн голоор голлон нутагладаг, Монгол Улсад алдартай анхны ардын эмч Д.Пүрэв, ардын багш, боксын алдарт дасгалжуулагч Д.Банди, Москвагийн олимпийн мөнгөн медальт, Улсын начин Ж.Даваажав нараас авахуулаад монголдоо болон дэлхийд нэрээ дансалсан олон арван алдартан төрсөн анхдагчдын өлгий нутгийн нэг юм.

Төслийн хүрээнд 2019 оны 7-р сарын 15-18-нд Хэнтий аймгийн Батширээт суманд болох “Ёохор хатар – 2019” наадмын үеэр манай төслийн багийн гишүүд хээрийн шинжилгээгээр явав. Тухайлбал, доктор М.Одмандах үндэсний сурын харвааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага ямар байх талаар нутгийн харваачид, ахмад настануудтай

уулзаж, ярилцлага хийв. Буриад судлалын академи Хэнтий Батширээт сумын ЗДТГ, ИТХ-тай хамтран, тухайн үеийн БСШУСЯ-ны дэмжлэгээр Соёлын өвийн төвтэй хамтран “Ёохор-2019” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгуулж, тус хурлын илтгэлүүдээр жижиг эмхэтгэл хэвлүүлж, төслийн тайланг олон нийтэд нэгэнт түгээгээд байна.

Мөн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хотын Эвенк хошууны Шинэхээн буриадудтай холбоо тогтоож, тэдний аж төрөл, ахуй байдлыг судлах, ардын аман зохиол болон бусад эд өлгийн зүйлд судалгааг амжилттай эхлүүлж, доктор М.Одмандах нутгийн өндөр настан, ахмад багш, харваач Дэлгэр, харваач Батдалай, Дамдин, Жигмэд нартай уулзаж, сурын харваа, үндэсний спортын төрлүүдийн уламжлал, хөгжил, төлөвшлийн талаар ярилцаж, мэдээлэл цуглуулж авав.

Яруу найрагч На.Сэмжид, багш, зан үйл судлаач, Хөлөнбуйр дээд сургуулийн багш Толон, Ажил мэргэжлийн дээд сургуулийн багш, судлаач, профессор Б.Цэнгэл нартай ярилцаж Шинэхээн буриадын уламжлал, зан үйлийн өнөөгийн байдал, тус газраас төрсөн ахмад нэрт буриадудын намтар, түүнд холбогдох мэдээллийг аман сурвалжлагаар авав. Тухайлбал, ахмад багш, нам төрийн зүтгэлтэн С.Батмөнх гуайтай ярилцаж, түүний амьдрал, намтарыг судлаж, хөрөг найруулал бичив. Цаашид тус нутгийн буриадудын сурын харвааны өнөөгийн байдал, хөгжлийн явцыг судалж, гурван гүрний буриадудын сурын харвааны ижил болон ялгаатай талыг нарийвчлан судалж, тусгай ном болгон гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

Монгол угсаатны биет бус соёлын өвийн дотроос бичгийн соёл хэлбэрээр хадгалагдаж буй ном зохиол, сурвалжийн дотор өгүүлэгдэх зарим нэр томьёо, нэр нэршил, үг хэллэг бүхий соёлын олонлог юуг зааж, юуг илэрхийлж буй бэлгэдэлзүйн учир холбогдлыг ойлгож мэдэх нь угсаатны аман зохиол, аман соёлд ихээхэн ач холбогдолтой билээ. Иймд доктор Л. Оюунцэцэг буриадудын угсаатны соёл, ялангуяа дээл хувцас зүүсгэлийн соёлд хамаатах судалгааны баримт бичиг, ном судар, биет бус өвийн судлагдахуунуудаар хайлт хийх, судлах ажлыг нэлээд дорвитой хийж байна. Жишээ нь: Монголын нууц товчооноо өгүүлэгдэх “шивэргэл” гэх гээг үсний нэр нэршил нь чухам юуг зааж байгаа, ялангуяа Дундад зууны түүхэнд холбогдох Өүлэн хатны шивэргэл гээгний оноосон нэр нь буриад-монголчуудын дунд “шэбэргэл” нэрээр мөнхүү уламжлагдан ирсэн хийгээд эдүгээд хүрч ирэхдээ чухам юуны учир уламжлан хадгалагдсаар байгаа, мөн нийгмийн хөгжлийн урт удаан эрин зууны туршид бусдын соёлтой уусан нийлсэн, холилдон ондоошсон эсэх зэрэг нь нэн сонирхолтой байгаа тул тэдгээрийн учир холбогдлыг олж тогтоох, харьцуулан үзэх, тайлан тайлбарлах оролдлого хийхийн зэрэгцээ монгол нутгаас олдож буй археологийн олдвороор нэхэн үзэж, бататган судлахыг зорьж ажиллажээ. Үүнийхээ үр дүн болгож Л. Оюунцэцэг, ОХУ-ын эрдэмтэн Д.Жамсуеватай хамтран "Өүлэн үжиний “шивэргэл” гээгийг буриад эхнэрийн “шэбэргэл” гээгтэй харьцуулан үзэж, археологийн олдвороор мөшгин тодруулах нь", “Буриад үндэсний хувцас, бэлгэдэл зүйн онцлог” судалгааны өгүүлүүдийг хэвлүүлээд байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ

Буриад монголчуудын тухай судалгааны эх хэрэглэгдэхүүнийг Монгол Улсад 1970-1990 он хүртэлх хугацаанд ШУА-ийн хүрээлэнгүүд, их, дээд сургуулийн эрдэмтэд сурвалжлан цуглуулсан хэдий ч зарим нь эрдэм шинжилгээний эргэлтэнд ороогүй, эх материал нь хадгалалтын буруугаас болж устах, дахин сэргэхээргүй болж үгүй болсон зэрэг шалтгааны улмаас үрэгдэж, олон нийтэд төдийлөн хүртээмжтэй биш байв.

Мөн өнөө хэр нь Монгол улсад буриадын угсаатны соёл, ялангуяа аман зохиолын уламжлал, угсаатны /бөө мөргөл хийгээд буддын/ загварчлал, прагматик-ашиглалт, эх хэлний уламжлалыг дамжуулагчдын бүтэц, хувьслын талаас нь судлаагүй байна. Орос, Хятадад бага угсаатны хүрээнд энэ сэдэв нь барууны шинжлэх ухааны цогц хэсэгт тусгагдаагүй байна.

Иймд Орос, Монгол, Хятад улсад амьдран суудаг буриад угсаатны бүлгийн аман соёлын үндсэн эхүүдийг хадгалагдаж ирсэн байдал болон хувирал өөрчлөлтийн харьцуулсан судалгаа хийх, буддын болон бөө мөргөлийн уламжлалыг угсаатны зүйн талаас нь судалж, угсаатны цөөнх болсон буриадын соёл уламжлалыг хадгалахад энэ төсөл нь чиглэгдэнэ. Аман зохиолын буюу аман соёлын төрөл зүйл угсаатан зүйн холбоо, хэл, соёлын хүрээний харилцааг харьцуулан судлах үндсэн зорилготой. Энэ хүчин зүйлээр дамжуулан оросуудын дундах буриад монголчуудын уламжлалыг хадгалах, улмаар монголчуудын дунд эх хэлний соёл уламжлалыг хадгалахад чиглэгдэнэ. Бөө мөргөлийн болон буддын сэтгэлгээний /оюун санааны/ хэрэглэгдэхүүний соёлын гарвал угсааг уламжлал инновацийн харилцан үйлдлээр хөгжүүлэх боломжийг эрэлхийлэх, анхны эх хувилбараар нь хувилан олшруулахыг эрмэлзэнэ. Буриадын гурван салаагаар жишээ баримт татаж өөр хэлний дунд буриад угсаатны сэтгэлгээний онцлогийн хувьсал, угсаатны соёл уламжлал цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдсөнийг судална. Амьд уламжлал буюу эх материалыг голчлон судалж, угсаатан зүй хийгээд аман зохиолыг судлагдахуун болгон авч үзнэ. Төслийн судлагдахуун тус бүр нь бие даасан байх боловч харилцан уялдаатай, нэгдсэн зарчимтай, системчлэгдсэн байна. Үр дүн нь баримтад тулгуурласан дүгнэлттэй байх бөгөөд төслийн гол зорилго болох Орос, Монгол Хятадын буриадын аман соёл, аман зохиол, угсаатны соёлыг хадгалж авч үлдэхэд чиглэгдсэн байна.

Судалгааны арга зүйн хувьд Үг хэллэгийн утга зүй-герменевтический, танихуйн хэл шинжлэлийн, дескриптивный, түүх-хэв шинжийн, бүтэц-үүргийн, статистикийн-газрын зургийн зэрэг архивын болон аман соёлын судлагдахууныг онолын хувьд ерөнхийлөн дүгнэж, харьцуулсан анализ хийнэ. Орчин үеийн гадаадын болон дотоодын судалгааг харьцуулан судлахаас аман зохиолыг угсаатан зүйтэй холбон судлах нь илүү үр дүнтэй, өгөөжтэй судалгааны арга болох юм.

ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР

/Техникийн даалгавар/

№	Төслөөр бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	Үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа (он, сар)
1	Эрдэм шинжилгээний өгүүлэл (гадаадад-8 дотоодод-8)	16	Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний бичигт судалгааны өгүүлэл хэвлүүлсэн байна	2020 оны 6 сар
2	Буриад судлалын академитай хамтран эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна	1	Хурлын илтгэлүүдийг эмхэтгэн хэвлүүлнэ	2020 оны 10 сар
3	Орос, Монгол, Хятад гурван улсад буй буриадуудын аман соёл нь угсаатны зүйн хүчин зүйл болох нь	1	Судалгааны эмхэтгэл хэвлэлийн эхээр бэлэн болсон байна	2020 оны 12 сар
4	Төслийн эцсийн тайлан бичиж хүлээлгэн өгнө	1	Эцсийн тайлан	2020 оны 12 сард багтаана

ТӨСЛИЙН КАЛЕНДАРЬЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ

	Д/д	Гэрээнд заагдсан тодорхой үе шатны ажлын нэр	Гэрээнд заагдсан хугацаа (Он,сар)	Гэрээнд заагдсан ажлын үр дүнгийн товч танилцуулга	Биелэлтийн үнэлгээ /хувиар/
Судалгаа боловсруулалтын ажлаар гүйцэтгэх ажлын календарчилсан төлөвлөгөө	2018 ОН				
	1	Монгол Улсын архивт сууж Монгол руу нүүсэн буриад, буриадуудтай хамт нүүж явсан оросын тухай, 1960 оноос өмнө цуглуулсан буриад аман зохиолын тухай баримт хэрэглэгдэхүүн цуглуулна	8-11 сар	Архивын материалыг үзэн судалж, Оросын талын судлаачтай хамтран судалгааны 2 өгүүлэл бичив	100 хувь
	2	Улан-Үдийн номын санд сууж, буриадын эрдэмт лам нарын холбогдолтой материал, эх сурвалж үзнэ	9 сар	Эх сурвалжаас боловсруулан эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэв. Оросын талын судлаачтай хамтран 2 өгүүлэл хэвлүүлэв	100 хувь
	3	Монголын буриадуудын нүүж ирсэн тухай, тэдний аман зохиолын тухай Монгол улсын буриад нутгаар хээрийн шинжилгээний ангиар явж материал цуглуулна	8 сар	Төслийн гэрээ 8 сарын 29-нд батлагдсан тул байгаль цаг уурын шалтгаанаас болж энэ ажил хойшлогдов. Гэвч судлаачид өөрсдийн өмнө цуглуулсан материалдаа түшиглэн судалгааны тус бүр 2 өгүүлэл Оросын талтай хамтран бичив	100 хувь
	4	Төслийн явцын тайланг санхүүжүүлэгч, захиалагчид тайлагнах	12 сард	Төслийн явцын тайлан бичиж илгээсэн	100 хувь

2019 ОН

Судалгаа боловсруулалтын ажлаар гүйцэтгэх ажлын календарчилсан төлөвлөгөө	1	Судалгааны эх хэрэглэгдэхүүн цуглуулна, уншина, боловсруулна	1-6 сар	Судалгааны эх хэрэглэгдэхүүн цуглуулж, жилийн эцэст Монголд 4, Орост 4 өгүүлэл хэвлүүлсэн	100 хувь
	2	Төслийн явцын тайланг санхүүжүүлэгч, захиалагчид тайлагнах	6 сар 12 сар	Төслийн явцын тайлан бичиж илгээсэн	100 хувь
	3	БНХАУ-ын Хөлөнбуйр аймагт хээрийн судалгааны ажил явуулах	9-10 сар	2019 оны 11 сараас Хөлөнбуйрын шинэхээн буриадын дунд ажиллаж, эх сурвалж, аман түүхийн материал цуглуулсан	100 хувь
	4	ОХУ-ын Буриадад хээрийн шинжилгээний ангиар явах	8 сар	Зам харилцааны байдлаас шалтгаалан 2019 оны 10 сард Улан-удэ хотноо томилолтоор ажиллав	100 хувь
	5	Монголын буриадуудын нүүж ирсэн тухай, тэдний аман зохиолын тухай Монгол улсын буриад нутгаар хээрийн шинжилгээний ангиар явж материал цуглуулна	2018 оны 8 сар	2018 оны төслийн мөнгө ороогүй байснаас шалтгаалж орхигдуулсан ажлаа нөхөж, Булган аймгийн Тэшиг суманд ажиллав	100 хувь

2020 ОН

	1	Буриад судлалын академитай хамтран зохион байгуулах эрдэм шинжилгээний хурлын бэлтгэл ажил, удирдамж, хөтөлбөр, урилга боловсруулна, тараана. Хуралд оролцогч нартай	1-7 сар	2022 оны 4 сарын 2-нд эрдэм шинжилгээний хурал хийв.	100 хувь
--	---	--	---------	--	----------

		холбоо тогтооно, бүртгэл явуулна.			
	2	Буриад судлалын академитай хамтран “Буриадын аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралт” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна	8 сар	Ковидын нөхцөл байдлаас төслийн санхүүжилт 2022 оны эхний сард орж ирсэн тул илтгэлийн эмхэтгэл хэвлүүлэх ажлыг 2022 оны 5-р сард хийв.	100 хувь
	3	Орос, Монгол, Хятад гурван улсад буй буриадуудын аман соёл нь угсаатны зүйн хүчин зүйл болох нь судалгааны эмхэтгэл бичнэ.	12 сар	3 жилийн хамтарсан судалгааны ажлын үр дүнг нэгтгэн эмхэтгэж, “Орос, Монгол, Хятад гурван улсад буй буриадуудын аман соёл нь угсаатны зүйн хүчин зүйл болох нь” судалгааны эмхэтгэл хэвлүүлэв.	100 хувь
	4	Төслийн эцсийн тайлан бичиж хүлээлгэн өгөх	12 сар	Төслийн эцсийн тайлан, үр дүнг хүлээлгэн өгөв.	100 хувь

ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

Монголын талаас:



Дамбийхорлоогийн Наранцэцэг

Төслийн удирдагч

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Сурвалж бичиг, төвөд судлалын салбарын эрхлэгч, хэл бичгийн ухааны доктор (Ph.D), профессор

Өгүүлэл-10

1. Наранцэцэг Д., Дампилова Л.,С. Мифологические мотивы в легендах и реданиях о Чингисхане //Республике Бурятия-95 лет: сб. науч. ст. -Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2018. -с 279-281
2. Д. Наранцэцэг. Буриад лам нарын намтар зохиолоор Буриадад шашин дэлгэрсэн түүхийг нөхвөрлөх нь. //Төвөд судлал. Уб., 2018. Боть 7, Дэвтэр 8. 158-180-р талд
3. Наранцэцэг Д., Сундуева Е., В. Буриадын эрдэмтэй лам Галсанжамбын орчуулсан "Бурхан багшийн намтар" зохиолын эх бичгийн шинжлэл. //Шинжлэх ухааны академийн хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бичиг. Төвд судлал. Уб., 2019. Том 8. Fasc 8. 111-118-р тал
4. Бураева, О. В., Наранцэцэг Д. Русские в Монголии: свидетельство А. И. Маслова //Современная научная мысль. М., 2019. №6, с167-176
5. Наранцэцэг Д. Монгольские буддийские обряды и церемоний. // Миряне и ламы: Буддийские идеи и практики в трансформирующихся обществах России и Монголии. Ответственный редактор д-р, ист. наук, проф. Л. Л. Абаева. Улан-Удэ: из д-во БНЦ СО РАН, 2019. стр 284-289
6. Наранцэцэг Д. Сундуева Е., В Шинэхээн Буриадын мэнгэ андалдах зан үйлийн өнөөгийн байдал. //Монголын соёл урлаг судлал. Уб., 2020. Том XXXV, Fasc 5. 53-61-р тал

7. Наранцэцэг Д., Дампилова Л.,С. Орос, Монгол, Хятад гурван улсын буриад угсаатны аман зохиол, аман соёл, угсаатны соёлын хамгаалалт, хувиралт. //Монголын соёл урлаг судлал. Уб., 2020. Том XXXIX, Fasc 8. 88-96-р тал
8. Л. С. Дампилова, Д. Наранцэцэг. Символический язык шаманских песнопений бурят России и Монголии. DOI 10.25882/xgfb-hb63.//Mongolica, Vol. XXIII, Saint Peterburg, 2020,
9. Д. Наранцэцэг. Об удзумчинском авторе сочинения "Комментарий к Сердечному покрову". DOI; 10.22162/2500-1523-2021-4-685-693, UDC 930/929, Mongolian Studies, Elista, 2022, Т.13, стр.685-693
10. Баярчимэг Э., Наранцэцэг Д. Буриад аялгууны үгийн сангийн зарим онцлогоос. //Буриад судлал сэтгүүл, 2022, Том 11, Fasc 8, 61-75

Илтгэл-4

11. Наранцэцэг Д. Буриадын эрдэмтэй лам Галсанжамбын орчуулсан “Бурхан багшийн намтар” зохиолын тухай. “Бичгийн өв ба монголчуудын түүх соёлын чухал асуудлууд” олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. ОХУ, Улан-Үдэ. 2017.09.08
12. Наранцэцэг Д. Сундуева Е. В. Буриадад шашин дэлгэрсэн түүхийг буриад лам нарын намтар зохиолоор нөхвөрлөх нь. -*МУИС-аас зохион байгуулсан “Буддизм ба тогтвортой хөгжил” олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. 2018.11.02*
13. Наранцэцэг Д., Дампилова Л.,С. Орос, Монгол, Хятад гурван улсын буриад угсаатны аман зохиол, аман соёл, угсаатны соёлын хамгаалалт, хувиралт. Соёл урлаг судлалын хүрээлэнгийн 45 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Улаанбаатар, 2020.02.24
14. Баярчимэг Э., Наранцэцэг Д. Буриад аялгууны үгийн сангийн зарим онцлогоос. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Буриад судлалын академи хамтран зохион байгуулсан "Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралт" олон улсын хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Улаанбаатар. 2022.04.02

Эмхэтгэл-2

1. Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралтын судалгаа. Эрхэлсэн Д.Наранцэцэг, М.Одмандах. Улаанбаатар., 2022
2. Буриад судлал. Боть-11. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Эмхэтгэсэн М.Одмандах, Л.Оюунцэцэг. Редактор Д.Наранцэцэг. Улаанбаатар., 2022

Тайлан-1

1. "Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралтын судалгаа" төслийн тайлан. Уб., 2022



Мягмарсүрэнгийн Одмандах

Төслийн гүйцэтгэгч

Буриад судлалын академийн ерөнхийлөгч

МУБИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор

Эрдэм шинжилгээний өгүүлэл-4

1. Сундеева Е. В., Одмандах М. “Этнокультурные связи Русских и Бурят в Монголии” өгүүллийг бичиж “Манускрипт” олон улсын цахим сэтгүүлийн 2019 оны Том 12. Выпуск 10-рт /С. 108-112. ISSN 2618-9690/, <http://www.gramota.net/materials/9/2019/10/20.html>
2. М. Одмандах. Булган аймгийн Тэшиг сумын буриадын уламжлалт соёлын хувиралт, хадгалалт. МУБИС-ийн “Монгол судлалын чуулган”, Уб., 2019, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдсэн. №59.
3. М. Одмандах. Буриадын үндэсний наадам, спортын хувиралт, өөрчлөлт, өнөөгийн байдал. //Буриад судлал сэтгүүл, 2022, Том 11, Fasc 10, 86-107
4. Цыбикова Б. Б., Одмандах М. “Мифологический пласт в устных произведениях сказочной прозы бурят”. //Бурятия-95, Улан-Удэ., 2018, стр. 282-283

Илтгэл-6

1. Одмандах М. “Монголын буриадын нүүдэл, суурьшил”. -Япон улсын Шова их сургуульд болсон “XX зууны монголын ертөнц: эргэн харах нь” олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. 2018.11.06
2. М. Одмандах. Улз голын буриадууд. Буриад судлалын академи, Д.Жаргалсайхан сан, Монгол улсын Консерваторийн хамтран зохион байгуулсан “Дэлхийд танигдсан дуучин-Д.Жаргалсайхан 80” гэсэн эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. УБ хот. 2019.03.22

3. М. Одмандах. “Батын Нямаагийн “Арандалынхан” роман дахь буриадын тухай дүрслэл, түүний онцлог” илтгэлийг профессор Саян Жимбеевич Балдановын 85 насны ойд зориулан ОХУ-ын Буриад улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, Дорж Банзаровын нэрэмжит БУИС, Дорно дахины дээд сургууль, Буриад хэл, уран зохиолын сургууль, Буриад, эвэнк хэлний тэнхимийн хамтран зохион байгуулсан “Сибирь – ардын аман зохиол ба уран зохиолын үндэстний орон зай” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хурал. 2020 оны 12-р сарын 10-11.
4. М. Одмандах. “Ж.Цэвээн ба Шинэ толь хэмээх бичиг сонины түүхийн үнэнийг тодруулах асуудалд”. Их соён гэгээрүүлэгч Шарайд Жамсраны Цэвээний мэндлэсний 140 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн эрдэм шинжилгээний хурал. Их засаг олон улсын их сургууль, 2021.10.16.
5. М. Одмандах. “Гончигдамбын Дарамзагдын уг гарвал” илтгэлийг Монголын хөгжмийн нэрт зохиолч, найрал дууны удирдаач Гончигдамбын 90 жилийн ойд зориулсан “Г.Дарамзагд амьдрал, уран бүтээл судлал-2021” эрдэм шинжилгээний бага хурал. 2021 оны 11-р сарын 24-ны өдөр. Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга, Офицеруудын ордон, Соёмбо танхим.
6. М. Одмандах. Буриадын үндэсний наадам, спортын хувиралт, өөрчлөлт, өнөөгийн байдал. . ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Буриад судлалын академи хамтран зохион байгуулсан "Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралт" олон улсын хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Улаанбаатар. 2022.04.02
- 7.

Эмхэтгэл-2

1. Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралтын судалгаа. Эрхэлсэн Д.Наранцэцэг, М.Одмандах. Улаанбаатар., 2022
2. Буриад судлал. Боть-11. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Эмхэтгэсэн М.Одмандах, Л.Оюунцэцэг. Редактор Д.Наранцэцэг. Улаанбаатар., 2022



Лувсангийн Оюунцэцэг

Төслийн багийн гишүүн

Буриад судлалын академийн Эрдэмтэн
нарийн бичгийн дарга, доктор

Эрдэм шинжилгээний өгүүлэл-5

1. Оюунцэцэг Л., Жамсуева Д. С. “Хууяа шилэ” дууны өгүүлэмжээс угсаатны соёлыг олж сонордохуй. //Монголын соёл урлаг судлал. Уб., 2018. Том XXIX. Fasc 24. 218-233-р тал
2. Жамсуева Д. С., Оюунцэцэг Л. “Цугольский и шэнэхэнский дацаны в сравнительном аспекте” *ВЛАСТЬ Общациональный научно-политический журнал. Улан-Удэ 2018., №09. Т. 28. Стр 212-219*
3. Оюунцэцэг Л., Бадамханда Ц. Б. Өүлэн үжиний "шивэргэл" гэзгийг буриад эхнэрийн "шибэргэл" гэзэгтэй харьцуулан үзэж, археологийн олдвороор мөшгин тодруулах нь. //Монголын соёл урлаг судлал. Уб., 2019. Том XXXIII. Fasc 3. 27-39-р тал
4. Жамсуева Д., Оюунцэцэг Л. Ритуальные аспекты мистерии Цам в бурятских дацанах. *Власть //Общациональный научно-политический журнал. №3 /27/ Улан-уде. 2019., стр189-193*
5. Л. Оюунцэцэг. “Соёлын өв: Тэшигийн буриадуудын үндэсний хувцасны хадгалалт, хувиралт”. //Буриад судлал сэтгүүл, 2022, Том 11, Fasc 11, 108-124

Илтгэл-2

1. Л. Оюунцэцэг. “Соёлын өв: Тэшигийн буриадуудын үндэсний хувцасны хадгалалт, хувиралт”. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Буриад судлалын академи хамтран зохион байгуулсан "Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралт" олон улсын хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Улаанбаатар. 2022.04.02
2. Оюунцэцэг Л. Буриад судлалын академийн үүсэл, хөгжил. -*ОХУ-ын Буриадын Их сургуулийн профессор Цей жаб Цыдыповын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан*

олон улсын эрдэм шинжилгээний хурал "Языки и литературы монгольских народов: теория и практика"-д хэлэлцүүлсэн илтгэл. Улан-удэ. 2019.10-24

Ном-10

1. Л.Оюунцэцэг. Бэрхийг туулсан басгад. Уб., 2021
2. Л. Оюунцэцэг. Тэшиг тийш сэтгэл татагдана. Аян замын тэмдэглэл. Уб., 2019
3. Л. Оюунцэцэг. "Тоонтымни хүхэ шулуун". Шүлгийн түүвэр. Уб., 2020
4. Л. Оюунцэцэг. Гүүртэдэ. Шүлгийн түүвэр. Уб., 2020
5. Л. Оюунцэцэг. Хайрханаймни бэшэрэл. Шүлгийн түүвэр. Уб., 2020
5. Сергей Бахлаев. "Молон багш", хөрвүүлсэн Л. Оюунцэцэг. Уб., 2021
6. "Балжин хатан". Монгол хэлний буриад аялгаас халх аялганаа хөрвүүлсэн Л. Оюунцэцэг. Уб., 2021
7. Г. Гантогтох. "Монголоу нюуса тобшоон". редактор Л. Оюунцэцэг.
8. Дэд хурандаа Чимиддоржийн Аюуш. Хөрөг дурсамжийг Л. Оюунцэцэг.
9. Бүмбэй баряашын эди шэди. Хөрөг дурсамжийг Л. Оюунцэцэг.

Эмхэтгэл-2

1. Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралтын судалгаа. Эрхэлсэн Д.Наранцэцэг, М.Одмандах. Улаанбаатар., 2022
2. Буриад судлал. Боть-11. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Эмхэтгэсэн М.Одмандах, Л.Оюунцэцэг, О.Баттуяа. Редактор Д.Наранцэцэг. Улаанбаатар., 2022



Очирын Баттуяа

Төслийн багийн гишүүн

Мандах ИС-ийн ахлах багш, доктор

Эрдэм шинжилгээний өгүүлэл-5

1. Баттуяа О., Цыбикова Б. Б. Буриадын шашин мөргөлийн уламжлалын асуудалд //Монголын соёл урлаг судлал. Уб., 2018. Том XXIX. Fasc 5. 58-66-р тал

2. Сундуева Е. В., Баттуяа О. “Мотивы номинаци в топонимии Кяхтийнского района Республики Бурятия. //Найдаковские чтения-4 Тюрко-Монгольский мир, гуманитарные исследования, Изд БНЦ СО РАН Улан-Удэ-2018

3. Баттуяа О, Жамсуева Д. С. Оросын нөлөөн доорх буриадуудын газар эзэмшил ба угсаатны үйл явц. //Монголын соёл урлаг судлал. Уб., 2019. Том XXXIII. Fasc 5. 47-54-р тал
4. Цыбикова, Б. Б., Баттуяа О. Сохранение родного языка в полиэтнических общностях (анализ опыта бурят Внутренней Монголии Китая). //Языки в полиэтническом государстве развитие, планирование, прогнозирование. Улан-Удэ, 2019, стр 205-207
5. Баттуяа О. 20-р зууны Монголын угсаатны хөгжлийн явц дахь буриад, хамниган. //Буриад судлал сэтгүүл, 2022, Том 11, Fasc 3, 24-30
- 6.

Илтгэл-2

1. Баттуяа О. Монголын хамниганы хэл аялгуу. -ОХУ-ын Буриадын Их сургуулийн профессор Цей жаб Цыдыповын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал "Языки и литературы монгольских народов: теория и практика"-д хэлэлцүүлсэн илтгэл. Улан-удэ. 2019.10-24
2. Баттуяа О. 20-р зууны Монголын угсаатны хөгжлийн явц дахь буриад, хамниган. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Буриад судлалын академи хамтран зохион байгуулсан "Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралт" олон улсын хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Улаанбаатар. 2022.04.02

Эмхэтгэл-2

1. Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралтын судалгаа. Эрхэлсэн Д.Наранцэцэг, М.Одмандах. Улаанбаатар., 2022

2. Буриад судлал. Боть-11. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Эмхэтгэсэн М.Одмандах, Л.Оюунцэцэг, О.Баттуяа. Редактор Д.Наранцэцэг. Улаанбаатар., 2022

Оросын талаас:



Дампилова Людмила Санжибоевна, доктор ScD- Төслийн удирдагч

Оросын Шинжлэх Ухааны Академийн Сибирийн салбарын Монгол, Будда, Төвөд судлалын хүрээлэнгийн уран зохиол, аман зохиол судлалын тасгийн эрхлэгч.

Судалгааны чиглэл: аман охиол, уран зохиол.



Сундуева Екатерина Владимировна, доктор ScD, профессор

Төслийн багийн гишүүн

Оросын шинжлэх ухааны академийн Сибирийн салбарын Монгол, Будда, Төвөд судлалын хүрээлэнгийн хэл шинжлэлийн судлалын тасгийн эрхлэгч.

Судалгааны чиглэл: монгол хэлний үгийн сангийн зүй.



Жамсуева Дарима Санжиевна, доктор PhD

Төслийн багийн гишүүн

Оросын шинжлэх ухааны академийн Сибирийн салбарын Монгол, Будда, Төвөд судлалын хүрээлэнгийн философи, соёл, шашин судлалын тасгийн эрдэм шинжилгээний ахмад ажилтан.

Судалгааны чиглэл: буриад дацангуудын түүх.




Бураева Ольга Владимировна, доктор ScD,

Төслийн багийн гишүүн

Оросын шинжлэх ухааны академийн Сибирийн салбарын Монгол, Будда, Төвөд судлалын хүрээлэнгийн түүх, угсаатан зүй, нийгэм судлалын тасгийн эрдэм шинжилгээний хөтлөгч ажилтан.

Судалгааны чиглэл: угсаатан зүй.



Чимитдоржиева Гунсэма Нимбуевна, доктор PhD

Төслийн багийн гишүүн

Оросын шинжлэх ухааны академийн Сибирийн салбарын Монгол, Будда, Төвөд судлалын хүрээлэнгийн нарийн бичгийн дарга, хэл шинжэлэлийн тасгийн эрдэм шинжилгээний хөтлөгч ажилтан.

Судалгааны чиглэл: монгол хэлний үгийн сангийн зүй.

СУДЛАГДСАН БАЙДАЛ

Монгол угсаатны нэгэн бүлэг зон бол буриадууд юм. Буриад зон нийгмийн хөгжлийн явцад угсаа гарлын түүх, хэл яриа, шүтлэг бишрэл, зан зашил, бэлгэдэл зүйн өргөн утгаараа өөрийн гэсэн өвөрмөц соёлыг бүрдүүлж чадсан ард түмэн билээ.

Тэдний энэхүү уламжлалт түүх, соёлыг судлан шинжлэх, эрэн сурвалжлах, нэхэн хайх, олсныг тэмдэглэх, цаашид хөгжүүлэх, хойч үедээ өвлүүлэн үлдээхийн тулд бие даасан хээрийн шинжилгээний судалгаа явуулах, урьд хожид бичиж үлдээсэн түүхэн бичиг баримт, мэдээ занги бүхүйг архивын сан хөмрөгөөс ухан харж, судлан шинжилж, судалгааны эргэлтэнд оруулах явдал нэн чухал асуудлын нэг хэвээр байна.

Монгол судлалд нэгэн шижим болон судлагдаж эхэлсэн буриад-монголчуудын тухай судалгаа өдгөөгөөс 100 гаруй жилийн тэртээ эхэлж, манай нэртэй судлаачид өөр өөрсдийн чиглэлээр чамгүй бүтээлийг туурвиж, баялаг эх хэрэглэгдэхүүнийг бэлтгэж хойч үедээ өвлүүлсээр иржээ.

Анхлан Агын буриад гаралтай Шарайд омгийн эрдэмтэн Жамсрангийн Цэвээн Монгол дахь буриад судлалыг эхлүүлж, аман аялгуу, аман зохиолын баялаг өв цуглуулж, түүндээ тулгуурласан зарим өгүүлэл, судалгааны бүтээл туурвин үлдээсэн нь эдүгээ бидэнд ховор чухал эх хэрэглэгдэхүүн болж байна. Анхны судар бичгийн хүрээлэн байгуулахад идэвхийлэн зүтгэсэн түүний гавьяагаар өнөөдөр бид бахархалт олон сайн судлаачид, эрдэмтэдтэй болж, тэдний шавь нарын залгамжаар монгол судлал хөгжсөөр л байна.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Түүх угсаатны зүйн хүрээлэн, Археологийн хүрээлэн зэрэг судалгааны олон байгууллагын эрдэм шинжилгээний аялал, хээрийн шинжилгээний ангийн цуглуулсан аман зохиол, хэл аялгуу, түүх, угсаатны зүйн эх хэрэглэгдэхүүн өнөөг хүртэл судлах эзнээ хүлээсээр байгаа нь манай эрдэмтэд ямархан их эх хэрэглэгдэхүүн, материалыг авч үлдсэнийг харуулж байна. Цаашид ч бид ялгаагүй хээрийн шинжилгээний анги зохион байгуулж эх хэрэглэгдэхүүнийг нэмж цуглуулах, харьцуулан судлах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Монголын түүх угсаатан зүй, ардын аман зохиол, урлаг, утга, соёл судлал зэрэг судалгааны хүрээнд тодорхой эрдэмтэд судалгаа хийж, бидний бүртгэснээр ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Түүх угсаатны зүйн хүрээлэнгээс эрдэм шинжилгээний экспедицээр 10 гаруй удаа, Буриад судлалын академиас хоёр удаа Монголын буриадуудын амьдран суудаг аймаг, сумдаар явж, аман зохиол, түүх, угсаатны зүйн холбогдолтой эд өлөг, эх хэрэглэгдэхүүнийг сурвалжлан цуглуулж, хүрээлэн болон академийн сан хөмрөгт хадгалсан байна. Үүнээс гадна бусад байгууллага, хувь хүмүүсийн хийсэн судалгаа ч цөөнгүй буй. Гэвч нарийвчлан судалсан зүйл дутагдалтай хэвээр байгаа нь Монголд “буриад судлал” төдийлөн бие даасан судлагдахуун болж чадаагүйг харуулж байна. Энд түүхэн нөхцөл шалтгаан байсныг үгүйсгэх аргагүй. Хэдий тийм боловч энэ үед академич Б.Ринчин, түүхч, эрдэмтэн зохиолч Х.Пэрлээ, угсаатан судлаач эрдэмтэн Х.Нямбуу, доктор, профессор Б.Сумьяабаатар, Ж.Цолоо, Г.Гантогтох зэрэг манай ахмад судлаачид тодорхой хүрээ хязгаарын дотор буриад судлалыг урагшлуулж, илтгэл, өгүүлэл, ном

товхимол нийтлүүлж байсан нь сайшаалтай бөгөөд Монгол дахь буриад судлалын эх суурийг баттай тавьж өгсөн гавьяатай хүмүүс гэдгийг дурдах нь зүйтэй.

Өнөөдөр буриад-монголчуудын гарал угсаа, түүх, угсаатны онцлог, хэл аялгуу, аман зохиолын талаарх судалгаа тал бүрээс нь нягтлан бичих ажил эрчимжиж, ойрын жилүүдэд 10 орчим докторын зэрэгтэй судлаачид төрөн гарсан нь бидний бахархах зүйлсийн нэг юм. Буриад судлалаар Б.Сумьяабаатар “Буриадын угийн бичиг” /1964/ ном бүтээж байсан тэр цагаас хойш өдгөө 100 гаруй нэг сэдэвт бүтээл, 500 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл хэвлэгдсэн нь чамлахааргүй амжилт юм. Социализмын үед хийгдсэн судалгаа нь голдуу бүхэллэг байдлаар нь судалсан, эх хэрэглэгдэхүүнийг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулахад чиглэгдсэн байв. Энэ нь ч аргагүй юм. Анхны эх баримтуудыг судалгааны эргэлтэд оруулахад анхаарч байсны үр дүн байлаа.

1990-ээд оноос хойш ардчилсан монгол оронд ястан угсаатны судалгаа улам нарийсаж, дотоод зүй тогтол, төрөл зүйл, эх хэлний аман аялгууны онцлог байдлыг нарийвчлах, аливаа түүхэн үйл явдлыг бодитой, тодорхой гаргах, цаг үеийн байдлыг нь үнэн бодитоор үнэлж цэгнэх, хаалттай байсан нууц баримт мэдээллийг судалгааны эргэлтэд оруулах зэрэг ажлыг хийж, судалгаа төрөлжиж байгаа нь сайшаалтай. Үүний үр дүнд Г.Гантогтох, Ц.Цэрэн, Той.Галсан, Г.Батцэрэн, Т.Цэрмаа, А.Оюунтунгалаг, Б.Ширнэн, С.Алтанцэцэг, Б.Нацагдорж, Л.Оюунцэцэг, Ж.Чулуунбаатар нарын судлаачид эрдмийн зэргээ буриад судлалын чиглэлээр хүртэж, олон арван судлаачид бүтээл туурвилын нэгэн сэдэв болгон ном товхимол, гарын авлага, илтгэл, өгүүлэл бичиж олны хүртээл болгож байна. Тухайлбал, доктор, профессор Б.Сумьяабаатар, Ц.Цэрэн, А.Самбуу, доктор Б.Ширнэн, М.Одмандах, Г.Батзаяа, Л.Цэрэнчимэд, Д.Соронзон, Л.Оюунцэцэг, Ж.Чулуунбаатар, судлаач М.Бадамням, Ж.Бадамдаш, Д.Дамдинжав, Л.Галбаабадраа нарын хүмүүс тус бүрдээ өөр өөрийн сэдэв, чиглэлийн дагуу багагүй судалгаа хийж, олны хүртээл болгожээ.

Буриад судлалын чиглэлийн эрдэм шинжилгээний бага хурлууд 2000 оны үеэс эрчимжиж, 2000 онд зохион байгуулсан “Алтаргана-2000” наадамд зориулсан хурлыг Буриад судлалын академиас санаачлан Улаанбаатар хотноо хийж, түүний эмхтгэлийг эрхлэн хэвлүүлсэн энэ чиглэлийн анхны бүтээлч ажлуудын нэг болсон юм. Энэ ажил уламжлал болж, буриад судлалын холбоотой эрдэм шинжилгээний хурлууд, дугуй ширээний ярилцлагыг тогтмол давтамжтайгаар хийж ирлээ. Энэ жилд гэхэд манай төслийн багийнхан Буриад судлалын академи, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн нутгийн аялгуу, аман зохиол, сурвалж бичиг судлаач эрдэмтэдтэй хамтран буриад судлалын хурлыг амжилттай зохион байгууллаа.

Буриад судлалын чиглэлээр ОХУ-ын Буриад Улсын Их Сургууль, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Будда, Төвөд, Монгол судлалын хүрээлэнгийн эрдэмтэн багш нар ид ажиллаж, эрдэм шинжилгээний бага хуралд оролцох, өгүүлэл, илтгэлээ хэвлүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж ирсэн нь биднийг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсныг цохон тэмдэглэх нь зүйд нийцнэ.

Үүний зэрэгцээ ОХУ-ын ШУА-ийн Монгол, Төвөд, Будда судлалын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид ч манай зохион байгуулсан үйл ажиллагаанд хамтран ажиллаж, хурал зөвлөгөөнд оролцож, өөрсдийн бүтээл туурвилаа нийтлүүлсээр байна.

Буриад судлалын асуудлаар манай улсад 2000 онд Улаанбаатар хотноо “Алтаргана-2000” наадмын хүрээнд “Буриад монголчуудын угсаа-түүхийн зарим асуудал”, 2008 оны 4-р сард Хөвсгөл аймгийн Мөрөн хотод “Дархад, Буриад судлалын зарим асуудал”, мөн 5-р сарын 14-нд Дорнод аймагт Дорнод Монголын дээд сургууль, ОХУ-ын Буриад улсын их сургуультай хамтран “Буриад ертөнц: үзэл баримтлал ба хэл соёлын бодлого” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, 2008 оны 5-р сарын 23-нд Буриад Судлалын Академиас зохион байгуулсан “Буриад судлалын тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, 2008 оны 10-р сарын 22-нд Олон улсын буриад хэлний өдөрт зориулсан “Орчин үе ба буриад судлал” дугуй ширээний ярилцлага, эрдэм шинжилгээний бага хурал зэргийг хийсэн нь буриад судлаач эрдэмтдийн хувьд бүтээсэн хийснээ олон нийтэд түгээхэд ихээхэн ач холбогдолтой болсон юм. Үүнээс улбаалан 2010 оны 6-р сарын 23-24-ний өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо хуралдсан “Нүүдлийн соёл иргэншил ба буриад монголчууд” сэдэвт олон улсын хурал нь “Алтаргана-2010” олон улсын наадмын үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан бөгөөд тус хурал нь нүүдлийн соёл иргэншилд буриад монголчуудын оруулсан хувь нэмэр, түүхэн үүрэг, тэдний амьдралын хэв маяг гэх мэт олон талын сэдвийг хамарсан өргөн хүрээнд олон улсын түвшинд зохион байгуулсан анхны хурал юм.

2008 оноос эхлэн Буриад судлалын академи ISBN 978-99929-77-24-8 дугаар бүхий “Буриад судлал” эрдэм шинжилгээний бичгийг эрхлэн хэвлүүлж байна. Тус эрдэм шинжилгээний бичигт буриадын түүх угсаа гарал, соёл урлаг, утга зохиол хэл шинжлэлд холбогдох гадаад, дотоодын эрдэмтдийн эрдэм шинжилгээ, судалгааны болон сурталчилгааны өгүүлэл, аян замын тэмдэглэл хэвлэгдсэн нь буриад судлал, монгол судлалд оруулж буй томоохон хувь нэмэр билээ. Буриад судлал сэтгүүлийн энэ оны тусгай дугаарт бидний хэрэгжүүлж буй энэхүү төслийн үр дүнгээр бичсэн судалгааны өгүүллүүдийг эмхэтгэн гаргаж буйгаараа онцлог юм.

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ

Орос Монголын хамтарсан төслийг 2018 оны 8-р сарын 29-ий өдөр Монгол Улсын БСШУСЯ-ы төрийн нарийн бичгийн дарга батлан, төслийн хүрээнд гүйцэтгэх ажлын гэрээ байгуулав.

Төслийн удирдагч Д.Наранцэцэг тайлант хугацааны эхэнд Оросын талын төслийн удирдагч, ОХУ-ын Сибирийн ШУА-ийн Буриад улсын эрдэм шинжилгээний ахлах ажилтан, шинжлэх ухааны доктор, профессор Л.С.Дампиловатай уулзаж, онол арга зүй, судлагааны явцын талаар хэлэлцэж, судалгааны чиглэлээ тогтсон нарийвчлалсан төлөвлөгөө гаргаж, төслийн багийн гишүүдтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулав.

Төслийн гүйцэтгэгчид календарьчилсан төлөвлөгөөний дагуу ажиллаж, 2018 онд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн дуун ухааны хөмрөг, Үндэсний номын сан, Үндэсний төв архивт сууж мэдээлэл цуглуулах, Буриадын ахмад настнуудтай биечлэн уулзаж, аман зохиолын болон буриадын нүүдлийн талаар ярилцлага сурвалжлага авах зэрэг ажлыг хийв. Цуглуулсан баримт мэдээлэлд дүн шинжилгээ хийж, өмнөх судалгааны ажил, эх хэрэглэгдэхүүндээ үндэслэж эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлж, хэд хэдэн өгүүлэл бичиж нийтлүүлэв. Тухайн онд бичсэн өгүүллүүд судлаачдын өөрсдийнх нь судалгааны сэдэв дагуу бичигдсэн бөгөөд агуулгын хувьд Монгол Улс дахь буриад угсаатны нүүдэл, суурьшил болоод буриадын бурхны шашны үүсэл дэлгэрэлттэй голлон холбогдож байна.

Мөн төслийн багийн гишүүд Монгол Улсын Номын сангаас болон түүхэн сурвалжуудаас буриадын түүх, угсаатны зүйн холбогдолтой ном бүтээл судалж, XIX- XX зууны зааг үеийн буриадын аж төрөл, хүн амын шашин шүтлэг, боловсрол мэдлэгт холбогдох тоо баримт, мэдээ мэдээлэл цуглууллаа.

Үндэсний төв архиваас буриад нар 1910-аад оноос хойш өнөөгийн Монгол улсын улс төрийн хил хязгаар нутагт шилжин суусан үйл явц, Орос, Зөвлөлтийн ямар нэрт газраас, хэдийд, хаагуур дамжин орж ирсэн хийгээд, хэд хичнээнээрээ хаагуур нутагласан, тэдний аж төрөхүйн хэв маяг, хэрэглээний талаарх баримт мэдээлэл цуглуулав. *Тэдний нэлээд хэсэг нь Орос улсын харьяат Читийн округ, дээд Үдийн уезд, Читийн Адгалиг хошуу, Сүхийн районоос ирсэн ажээ. Ингээж ирсэн буриад, хамнигад 1925 онд Халх нөмрөг голын буриад хошуу, Улз голын буриад хошуу, Онон голын буриад хошуу, Хэрлэн голын буриад хошуу, Ерөө голын буриад хошуу байгуулагдахад түүнд харьяалагдаж суусан байна.*

Судалгааны дүнд Монгол улсад буриадууд 4 удаагийн нүүдлээр нүүж ирсээр 100 илүү жил болж байна. Бид энэ удаад буриадын нүүдлийн учир шалтгаан хийгээд, тэд хэрхэн суурьшиж, хаагуур нутаглаж, хүн амын хувьд ямар байсныг энэ удаа онцолж үзэв. Монголын буриадын нүүдэл, суурьшлын байдлыг түүхэн нөхцөл дунд нь авч үзэж, тэдний хүн амын тоо, тэдний боловсрол, бичиг соёлын чадамжийн тухай өгүүлснээс гадна сүүлийн үеийн хүн амын тоо, монголын статистикийн газрын мэдээнд тулгуурлан овог аймгийн бүтцээр нь судалж, нийт 137 орчим мянган буриадууд байгааг анх удаагаа тооцон гаргаж, олон нийтэд танилцуулсан нь гол ач холбогдол болов.

Буриадын нүүдлийн шалтгаан нь:

1. Оросын засгийн газраас буриадын талаар явуулсан хатуу бодлого, эзлэн түрэмгийлэх, малчдын аж амьдралыг хааж боосон, газар эзэмших зэргээр тэдний аж амьдралд хүндрэл бий болсон нь нутгаа орхин амар амгалан газар орныг зорих нэгэн шалтгаан болжээ,
2. Орост гарсан иргэний дайн, дэлхийн нэгдүгээр дайн зэрэг үймээн, дайны хөлөөс дайжиж амар тайван нутагт суурьших хэрэгцээ гарсан нь нүүдлийн өөр нэгэн шалтгаан байсан байна,
3. Монголчууд Манж чин гүрний дарлалаас ангижирч, Олноо өргөгдсөн Богд Хаант Монгол Улсыг байгуулсан нь үндэсний ухамсарыг сэргээж, монгол гэсэн зөн билэг, элгэмсүү хандлагыг өдөөж, угсаатны хувьд нэг гарвалтай монгол туургатныг нэгдэн нийлэх түүхэн нөхцлийг бүрдүүлсэн нь буриадудыг нүүж ирэх гол шалтгаан байжээ.
4. Дээрх шалтгаануудаас гадна нүүхэд түлхсэн сүсэг бишрэлийн нэгэн сэжим нь Молон багшийн лүндэн байсан нь ч нөлөөлсөн байна гэж бид үзэж байна.

Иймд буриадын Монгол руу нүүсэн шалтгааныг уг сурвалжаас нь угсаатны төлөвшил, ухамсар, сэтгэлгээний талаас нь нарийвчлан судалж, үнэлэлт дүгнэлт өгөх нь туйлын зөв чиг баримжаа гэж үзэж байна.

2019 онд төслийн оролцогчид төлөвлөгөөний дагуу Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн дуун ухааны хөмрөг, Үндэсний номын сан, Үндэсний төв архив, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвөд, Будда судлалын хүрээлэнгийн дэргэдэх гар бичмэл, модон барын төв, Хөлөнбуйрын Үндэстний сурвалж бичиг судлах хүрээлэнгийн номын сан зэргээс сан хөмрөгийн данс харааг шүүрдэн судалж буриадын аман түүх, угсаатны түүхийн сурвалжтай холбогдох мэдээ материалаас тэмдэглэл хийж, олшруулж авлаа.

Мөн БНХАУ-ын Хөлөнбуйр аймгийн Шинэхээн буриад, Монгол Улсын Булган аймгийн Тэшиг сумын ахмад настан буриад угсаатны төлөөлтэй биечлэн уулзаж, аман зохиолын болон буриадын нүүдлийн талаар ярилцлага сурвалжлага авах зэрэг ажлыг хийв. Цуглуулсан баримт мэдээлэлд дүн шинжилгээ хийж, өмнөх судалгааны ажил, эх хэрэглэгдэхүүндээ үндэслэж эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлж, өгүүлэл бичиж нийтлүүлжээ.

Төслийн оролцогч Доктор Л.Оюунцэцэг, О.Баттуяа нар ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хотод 5 хоногийн хугацаатай томилолтоор ажиллав. Томилолтоор ажиллах үедээ Буриадын Боловсрол Шинжлэх Ухааны Яам, Дорж Банзаровын нэрэмжит Буриадын Их Сургуулиас 10 сарын 23-24-нд зохион байгуулсан “Монгол угсаатны хэл соёл: онол, практик” эрдэм шинжилгээний хуралд “Монголын хамниганы хэл аялгуу” илтгэл тавьж оролцов. Энэ эрдэм шинжилгээний хурал нь тус сургуулиас зохион байгуулсан “Буриад хэлний өдрүүд” –ийн нэг арга хэмжээний нэг хэсэг юм.

Төслийн оролцогч М.Одмандах, Д.Наранцэцэг нар БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөлөнбуйр аймагт 7 хоногийн хугацаатай томилолтоор ажиллав. Томилолтоор ажиллах үедээ Хөлөнбуйр аймгийн Хайлаар дүүрэг, Нан түнь дүүрэг, Эвенк хошуу, шинэхээн

буриадын дунд очиж ахмад настныг сурвалжлан мэдээлэл цуглуулахын хамт Хөлөнбуйр их сургуулийн удирдлагуудтай уулзан, төслийн ажлын талаар санал солилцов.

Доктор(Ph.D) О.Баттуяа, Монгол улсын Үндэсний төв архивт ажиллаж 92, 101, 102, 132-р сан хөмрөгөөс судалгаанд холбогдох баримт, Монгол улсын номын сангаас буриадын түүх, угсаатны зүйн болон XIX- XX зууны зааг үеийн буриадын аж төрөл, хүн амын шашин шүтлэг, боловсрол мэдлэгт холбогдох тоо баримт, мэдээ мэдээлэл цуглууллаа.

Оросын талын төслийн судлаач Жамсуева Дарима Санжиевнагийн хамт 2019 оны 07 сарын 01-04-нд Улаан-Үд хотод зохион байгуулагдсан “Языки полиэтническом государстве: РАЗВИТИЕ, ПЛАНИРОВАНИЕ, ПРОГНОЗИРОВАНИЕ” олон улсын эрдэм шинжилгээний хуралд “Сохранение родного языка в полиэтнических общностях (анализ опыта Бурят Внутренней Монголии Китая)” илтгэл тавив. Тус илтгэлд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Эвенк хошууны буриадудын дунд буриад хэл соёл нь хэрхэн уламжлагдаж ирсэн, ямар үг хэл, аман сургаал хадгалагдаж байгааг харуулжээ.

Мөн судлаач Д.С.Жамсуевагийн хамтран “Оросын нөлөөн доорх буриадудын газар эзэмшил ба угсаатны үйл явц” өгүүлэл бичиж “Монголын соёл урлаг судлал” сэтгүүлд хэвлүүлэв. Буриадын уугуул аж ахуй, мөн соёлын зарим өөрчлөлт хувирлын талаарх энэ өгүүллийг өмнө онд хэвлүүлсэн Байгал тойрон нутаглаж байсан бус төрөлтнүүдийн (буриадын түүхийн сурвалжид Сибирийн уугуул ард түмнүүдийг орос биш гэсэн утгаар “бус төрөлтнүүд”/инородцы/ гэж нэрлэж байсныг бид тэр хэвээр нь ийн нэрлэж байна) нэг буриадудын шашин мөргөл нь хаант Оросын бодлого нөлөөгөөр хэрхэн замнаж ирснийг харуулахыг хичээсэн “Буриадын шашин мөргөлийн уламжлалын асуудалд” өгүүлэлтэй уялдуулж бичив. “Буриадын шашин мөргөлийн уламжлалын асуудалд” өгүүлэлд Оросын нөлөөн дээх буриадын шашин мөргөлийн асуудлыг хөндсөн бол энд аж ахуйн асуудлыг онцоллоо. Эртнээс нааш нүүдэлч малчин байсан буриад-монголчууд Оросын мэдэлд хамжигдсанаар ахуй соёлын зарим талаар тэдэнд уусан шингээд эдүгээ нэг хэсэг нь “оросын буриад” гэж үзэгдэн уг удам нэгт монголчуудтайгаа ижилсэх юмгүй шахуу болохдоо хүрээд байгаа бол XX зууны эхэн хэрд Монголд ирсэн буриадуд нь Оросоос тасарч ирсэн, оросын нэг хэсэг мэт үзэгдэх нь ч байна. Тус өгүүлэлд буриадыг ингэж үзэхэд хүргэсэн бусдын соёлын нөлөө, тэр нөлөөллийн түүх яаж эхэлсэн бэ?, түүнээс улбаатай газар эзэмшлийн асуудал, угсаатны үйл явц хэрхэн өрнөсөн бэ? энэ сэдвийг хөндөж түүхчилж бичив. Буриадын аж ахуй, соёлын үйл явц нь оросууд Монголын түшмэг хараат нутаг байсан Сибирийг эзэлж авсан түүхтэй ямагт холбоотой өрнөсөн байдаг. Иймээс нийт буриадын түүх, угсаатны зүйн судалгаанд, Монголын буриадын судалгаанд ч ялгаагүй энэ үеийг сөхөх хангалттай шалтгаан холбогдол байна гэсэн үг. Үүнийг анхаарч Монголын буриадын аж төрөлд оросын соёл тусгалаа олсон үйл явцыг оросууд өвөр Байгалд ирсэн ХҮИ зууны үеэс эхлүүлэв. Өнгөрсөнд өрнөсөн үйл явцыг зураглан сэргээхэд сурвалжийн мэдээ хамгийн том үүрэг гүйцэтгэдэг. XIX зууны буриадын түүхийн сурвалжийн мэдээг голлон ашиглалаа. Ямар ч ард түмний аж ахуй, соёл нь тэдний туулж өнгөрүүлсэн түүхэн замналтай салшгүй холбогдохын хамт нийгмийн хөгжлийг дагасан шинжтэй хувирч өөрчлөгдөж сайжран хөгждөг жамтай. Ойр

дөт хаяа хөрш нутаглаж буй ард түмэн ямар нэг хэлбэрээр соёлын солилцоонд орж бие биентэйгээ ахуй соёлын талаар адилсах нь зүй ёсных боловч тэр үйл явц нь сөрөг ба эерэг шинжтэй, тэрхүү соёлыг хүлээн зөвшөөрч тусган авах нь ч хоёрдмол үр дагавартай. Буриадын оросуудтай адилсах үйл явц мөн ийм замыг туулсан болохыг тоймлон бичив. Өгүүлэлэд буриадын түүхийн сурвалжийн мэдээ болон МУ-ын архивт хадгалагдаж буй зарим мэдээг олж тэмдэглэж авснаа ашигласан байна.

Доктор(Ph.D) Л.Оюунцэцэг Монгол угсаатны биет бус соёлын өвийн дотроос бичгийн соёл хэлбэрээр хадгалагдаж буй ном зохиол, сурвалжийн дотор өгүүлэгдэх зарим нэр томьёо, нэр нэршил, үг хэллэг бүхий соёлын олонлог юуг зааж, юуг илэрхийлж буй бэлгэдэлзүйн учир холбогдлыг ойлгож мэдэх нь угсаатны аман зохиол, аман соёлд ихээхэн ач холбогдолтой тул үүн лугаа судалгааны баримт бичиг, ном судар, биет бус өвийн судлагдахуунуудаар хайлт хийх, бичвэр хийх зэргээр ажиллаж байна. Жишээ нь: Монголын нууц товчооноо өгүүлэгдэх “шивэргэл” гэх гээг үсний нэр нэршил нь чухам юуг зааж байгаа, ялангуяа Дундад зууны түүхэнд холбогдох Өүлэн хатны шивэргэл гээгний оноосон нэр нь буриад-монголчуудын дунд “шэбэргэл” нэрээр мөнхүү уламжлагдан ирсэн хийгээд эдүгээд хүрч ирэхдээ чухам юуны учир уламжилан хадгалагдсаар байгаа, мөн нийгмийн хөгжлийн урт удаан эрин зууны туршид бусдын соёлтой уусан нийлсэн, холилдон ондоошсон эсэх зэрэг нь нэн сонирхолтой байгаа тул тэдгээрийн учир холбогдлыг олж тогтоох, харьцуулан үзэх, тайлан тайлбарлах оролдлого хийхийн зэрэгцээ монгол нутгаас олдож буй археологийн олдвороор нэхэн үзэж, бататган харах судалгаа шинжилгээний ажил боловсруулалтын байдалтай явагдаж байна.

2019 оны 7-р сарын 1-2-нд Булган аймгийн Тэшиг суманд зохион байгуулагдсан “Бага Алтаргана-2019” наадмын үеэр ОХУ-ын төслийн багийн гишүүдтэй хамтарсан хээрийн шинжилгээний ангиар явж ажиллав. ОХУ-аас 4 судлаач, Монголын талаас Одмандах, Оюунцэцэг нар оролцов. Хээрийн судалгааны ажлын үед нутгийн өндөр настан, сумын иргэдтэй уулзсанаас гадна монгол орны газар газраас ирсэн буриадуудын төлөөлөлтэй уулзаж, мөн ОХУ-ын Түнхэн аймгийн буриадуудтай уулзаж, өөрийн судалгааны чиглэлээр хувцас, эд өлгийн зүйлс, түүнтэй холбоотой аман зохиол, аман мэдээ цуглуулаж ажилласан болно.

Оросын талын оролцогч Д.Жамсуеватай хамтран "Өүлэн үжиний “шивэргэл” гэзгийг буриад эхнэрийн “шэбэргэл” гэзэгтэй харьцуулан үзэж, археологийн олдвороор мөшгин тодруулах нь" өгүүлэл бичиж Соёл урлаг судлалын хүрээлэнгээс гаргадаг “Монголын соёл урлаг судлал” сэтгүүлд хэвлүүлэв.

Буриадын Их Сургуулийн доктор, профессор Цей-Жаб Цыдыповын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан Олон улсын эрдэм шинжилгээний “Языки и литературы монгольских народов: теория и практика” сэдэвт хуралдаанд “Буриад судлалын академийн үүсэл, хөгжил” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

Доктор (Ph.D), дэд профессор М.Одмандах төслийн хүрээнд 2019 оны эхний хагас жилд төлөвлөгөөний дагуу судалгааны материал, аман зохиолын мэдээлэл цуглуулах ажлыг хийв. Буриад судлалын нэрт эрдэмтэн асан Г.Гантогтохтой биечлэн

ярилцаж, түүний цуглуулсан аман зохиолын эх хэрэглэгдэхүүн, гар бичмэлтэй танилцаж, зарим ховор гар бичмэлийг судалгааны эргэлтэд оруулахаар авав.

ШУА-ийн ХЗХ-ийн сан хөмрөгөөс зарим мэдээллийг үзэж, хуулбар хийж байна. Тус сан хөмрөгөөс бидний судалж буй сэдэвтэй холбоотой зарим мэдээллийг нягтлан магадлаж, судалгааны эргэлтэд ороогүй бүтээлүүдийг сонгон үзэж байна.

2019 оны 7-р сарын 1-2-нд Булган аймгийн Тэшиг суманд зохион байгуулагдсан “Бага Алтаргана-2019” наадмын үеэр ОХУ-ын төслийн багтай хамтарсан хээрийн шинжилгээний ангиар явж ажиллав. ОХУ-аас 4 судлаач оролцов. Энэ үед цуглуулсан аман мэдээлэл, үндэсний спортын хөгжлийн уламжлал, хөгжил, хувиралт, хадгалалтын нөхцөл байдлыг цэгнэн үзэж “Булган аймгийн Тэшиг сумын буриадын уламжлалт соёлын хувиралт, хадгалалт” өгүүллийг бичиж МУБИС-ийн “Монгол судлалын чуулган” эрдэм шинжилгээний сэтгүүлийн 2019 оны дугаарт хэвлүүлэв.

Хамтарсан багт ажиллахдаа урьдчилж бэлтгэл хангахын тулд 6-р сарын 29-ний өдрөөс эхлэн тус суманд очиж ажиллажээ. Хээрийн судалгааны ажлын үед нутгийн өндөр настан, сумын иргэдтэй уулзсанаас гадна монгол орны газар газраас ирсэн буриадуудын төлөөлөлтэй уулзаж, мөн ОХУ-ын Түнхэн аймгийн буриадуудтай уулзаж, аман зохиол, ардын дуу, хуур, үндэсний спорт, сурын харваа зэрэгтэй холбоотой мэдээлэл цуглуулж ажилласан болно.

Мөн ОХУ-ын төслийн багтай хамтарсан хээрийн шинжилгээний ангиар ажиллав. Судлаач Дарима, Бадма-Ханда нар ажиллаж, орон нутгийн ахмад настан, 10 гаруй хүнтэй уулзаж, аман мэдээлэл цуглуулж, зураг, бичлэг хийж авсан болно. Тэд уг мэдээлэлд түшиглэн өгүүлэл бичиж хэвлүүлсэн болно.

Тэшиг суманд цугласан буриад монголчуудтай уулзаж, эртний дуу, дууны үгийг бичиж, аялгууг сонсож, тэмдэглэл хийв. Нэн ялангуяа үндэсний спортын төрөл зүйлүүдийн хөгжилт, хандлага ямар байгааг судалж, ажиглалт хийж ирэв. Эртний монгол язгуурын аймгийн нэгэн буриадын Хонгоодор овгийн буриад нарын нутаглаж байгаа Тэшигийн Зэд нурууны ар, Тэшигийн давааны ар Эрэнгийн голоор нутаглаж байгаа буриад айл өрхийн аж амьдрал, ахуй байдлын талаар мэдээлэл цуглуулж, баримтжуулан зураг авч тайлан бэлтгэж байна. Тус сумаас төрсөн алдартнууд, тэдний намтар түүхийн талаар сонирхолтой шинэ баримтуудыг олж авав.

Наадмын үеэр болсон илтгэлийн уралдааны шүүгчээр ажиллаж, тус хуралд илтгэсэн 5 илтгэлийг бичгээр авч уншиж, олон сонирхолтой санаа, баримт олж үзэв. Тус мэдээлэл нь цаашдаа судалгааны эргэлтэд орох, санаа авах, нэн ялангуяа орон нутгийн түүх судлалд холбогдох нутгийн иргэдийн аман мэдээнд дүн шинжилгээ хийж, бусад түүхийн баримт, эх сурвалжтай харьцуулан үзэх боломж олдов.

Тэшиг суманд ажиллаж амьдрах буриадууд нь сумын хүн амын 25%-ийг эзлэх бөгөөд голчлон Зэдийн нурууны ар, Тэшигийн давааны ар Эрэнгийн голоор голлон нутаглах бөгөөд монгол улсад алдартай анхны ардын эмч Д.Пүрэв, Ардын багш, боксын алдарт дасгалжуулагч Д.Банди, Москвагийн олимпийн мөнгөн медальт, Улсын начин Ж.Даваажав нараас авахуулаад монголдоо болон дэлхийд нэрээ дансалсан олон арван алдартан төрсөн анхдагчдын өлгий нутгийн нэг юм.

Төслийн хүрээнд 2019 оны 7-р сарын 15-18-нд Хэнтий аймгийн Батширээт суманд болох “Ёохор хатар – 2019” наадмын үеэр хээрийн шинжилгээний ажлыг хийв. Энэ ажлаар үндэсний сурын харвааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандалга ямар байх талаар нутгийн харваачид, ахмад настануудтай уулзаж, ярилцав. Батширээт сумын ЗДТГ, ИТХ-тай хамтран, БСШУСЯ-ны дэмжлэгээр Соёлын өвийн төвтэй хамтран “Ёохор-2019” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгуулж, тус хурлын илтгэлүүдээр жижиг эмхтгэл хэвлүүлж, төслийн тайланг олон нийтэд түгээсэн байна. Энэ ажилд судлаач, БСА-ийн ерөнхийлөгчийн хувиар оролцож, ажиллав. Төслийн багийн гишүүн, доктор Л.Оюунцэцэг хурлыг зохион байгуулагчийн хувиар оролцож, эмхэтгэлийг хэвлүүлж түгээв.

Мөн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хотын Эвенк хошууны Шинэхээн буриадуудтай холбоо тогтоож, тэдний аж төрөл, ахуй байдлыг судлах, ардын аман зохиол болон бусад эд өлгийн зүйлд судалгаа хийх ажлыг 10-р сарын 25-наас 11-р сарын 2-ны хооронд Д.Наранцэцэгийн хамт хийж, судалгааны эх хэрэглэгдэхүүн цуглуулж ажиллав. Үүний хүрээнд М.Одмандах өндөр настан, ахмад багш, харваач Дэлгэр, харваач Батдалай, Дамдин, Жигмэд нартай уулзаж, сурын харваа, үндэсний спортын төрлүүдийн уламжлал, хөгжил, төлөвшлийн талаар ярилцаж, мэдээлэл цуглуулав.

Яруу найрагч На.Сэмжид, багш, зан үйл судлаач, Хөлөнбуйр дээд сургуулийн багш Толон, Ажил мэргэжлийн дээд сургуулийн багш, судлаач, профессор Б.Цэнгэл нартай ярилцаж Шинэхээн буриадын уламжлал, зан үйлийн өнөөгийн байдал, тус газраас төрсөн ахмад нэрт буриадуудын намтар, түүнд холбогдох мэдээллийг аман сурвалжилгаар авав. Тухайлбал, ахмад багш, нам төрийн зүтгэлтэн С.Батмөнх гуайтай ярилцаж, түүний амьдрал, намтарыг судлаж, хөрөг найруулал бичив. Цаашид тус нутгийн буриадуудын сурын харвааны өнөөгийн байдал, хөгжлийн явцыг судалж, гурван гүрний буриадуудын сурын харвааны ижил болон ялгаатай талыг нарийвчлан судалж, тусгай ном болгон бичихээр төлөвлөж байна.

Төслийн явцын хүрээнд гэрээнд заасны дагуу ОХУ болон Монголд тус бүр нэг хамтарсан өгүүлэл бичиж нийтлүүлэв. Үүний агуулгыг дор товч дурдвал:

Төслийн ОХУ-ын талын хамтрагч, Хэлбичгийн ухааны доктор Сундуева Екатерина Владимировнатай хамтран 10-р сард “Этнокультурные связи Русских и Бурят в Монголии” өгүүллийг бичиж “Манускрипт” олон улсын цахим сэтгүүлийн 2019 оны Том 12. Выпуск 10-рт /С. 108-112. ISSN 2618-9690/ хэвлүүлэв.

Тус өгүүлэлд “...Монгол оронд аж төрж, суурьшиж байсан орос иргэдийн тухай мэдээлэл судлаачдын анхаарлыг татдаг боловч нэгдсэн ойлголт, системтэй судалгаа бүрэн бус байна. Энэ талаар судлаач Х.Мэндсайхан тусгайлан судалж ном бүтээл туурвиснаас өөр дорвитой бүтээл алга. Нэн ялангуяа Оросоос нүүж ирсэн буриадуудыг дагаж орж ирсэн оросуудын тухай мэдээлэл тэр бүр алга. Аман эх сурвалжаас авсан зарим нэгэн мэдээлэл байх боловч яг таг батлагдсан баримт ховор байна. Иймд бид монгол судлаачдын бичсэн бүтээл туурвилаас оросууд хэрхэн суурьшиж, хүн амын хувьд ямархуу байсныг шүүрдэн үзэж, улмаар аман мэдээллийг харьцуулан шинжилж үзэв. Мөн монгол хүнд үрчлэгдсэн орос хүмүүсийн тухай зарим мэдээллийг энд авч үзлээ. Мөн энэ

өгүүлэлд Орос, Монгол дахь буриадын соёлын хувиралт, өөрчлөлт, монголд амьдарч байсан орос иргэдийн хүн амын тоо, өөрчлөлт, монголд үрчлэгдсэн орос хүмүүсийн намтар зэргийг тодруулан бичиж, өгүүлэл болгон хэвлүүлжээ.

ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Төвд, Будда, Монгол судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор Л.С. Дампиловатай хамтран “Булган аймгийн Тэшиг сумын буриадын уламжлалт соёлын хувиралт, хадгалалт” сэдэвт өгүүллийн товч утга нь “Монгол улсад суугаа буриадуудын уламжлал, соёл нь цагийн эрхээр хувирч байгаа хэдий боловч сүүлийн 30 орчим жилд сэргээх, хөгжүүлэх, хадгалах гэж тал талдаа анхаардаг болжээ. Үүний нэг жишээ нь монгол улсаас эхлэн өнөөдөр олон улсын хэмжээний болсон Алтаргана наадам юм. Тус наадам бий болсноор буриадуудын ухамсар сэтгэлгээнд уламжлалт соёлоо гэсэн хандлагыг бий болгосноор үгүй болох эрсдэлтэй соёл, уламжлалаа сэргээх, хадгалах үзэгдэл нийт буриадын дунд эрчимжиж байна. Энэ удаа бид Булган аймгийн Тэшиг суманд болсон “Бага Алтаргана-2019” наадмын үеэр хийсэн гүймэг судалгаанд тулгуурлан соёлын хувиралт, хадгалалтын талаар бичив.

Доктор Д.Наранцэцэг төслийн хүрээнд 2019 оны эхний хагас жилд төлөвлөгөөний дагуу судалгааны материал, аман зохиолын мэдээлэл цуглуулах ажлыг хийв.

7 сарын 11-25-ы өдөр ОХУ-ын Шинжлэх ухааны академийн Дорно дахин судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудтай хамтран, тэдний зардлаар хээрийн шинжилгээний ангиар явах дашрамд Монгол Улсын Булган, Хөвсгөл аймгийн нутагт суурьших буриадаас балчир насандаа нүүж ирсэн Сэлэнгийн Хушаатын шарнууд овогтой Дэмбэрэлийн Байгалмаа, Хөвсгөлийн Балжир бөө зэрэг ахмад настнуудтай уулзан, тэдний бага залуудаа сурсан дуу, хэлц үг, үлгэр түүхийг яриулж, тэмдэглэж авав.

ӨМӨЗО-ы Хөлөнбуйр аймгийн Хайлаар дүүрэг, Нан түнь дүүрэг, Эвенк хошуу, шинэхээн буриадын дунд очиж шинэхээн буриадын мэнгэ андалдах зан үйл, Шинэхээн нутагт нүүдэллэж ирсэн байдал, буриад монгол хэлээ сургаж сурч байгаа явц, буриадын аман түүх соёлын талаар сурвалжлан мэдээлэл цуглуулахын хамт Хөлөнбуйрын Үндэстний сурвалж бичиг судлах хүрээлэнгийн эх бичиг материалтай танилцан, эндээс олж авсан судалгааны материалдаа үндэслэн ОХУ-ын талын хамтрагч, Хэлбичгийн ухааны доктор, доцент Сундуева Екатерина Владимировнатай хамт "Буриадын эрдэмтэй лам Галсанжамбын орчуулсан Бурхан багшийн намтар зохиолын эх бичгийн шинжлэл" судалгааны өгүүллийг Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн Төвд судлал эрдэм шинжилгээний бичигт хэвлүүлсэн. Тус өгүүлэл нь Буриад барын судрын 346 хуудас **БҮХИЙ** 44.8×12 (36.6×8), 29–30 мөр, "Фабрики наследников Сумкина" гэсэн тэмдэгтэй орос цаас, улаан (эхний хоёр хуудас) хар бэхээр бичсэн ilaju tegus nsgčigsen čidayči-yin erke-tü-yin jokiyaI-i tobči-yin tedüyiken ögülegsen üjegseger tusa-tu masi bayasqulang-luy-a selte-ber süsülkü-yin naran-i jaγun jäg-tar urγuyuluyči kemegdeku orosiba хэмээх зохиолд хийсэн эх бичгийн шинжлэл юм.

Мөн Оросын талын хамтрагч шинжлэх ухааны доктор Бураева Ольга Владимировнатай хамтран "Монголд Оросууд суурьшсан нь" өгүүллийг бичиж Москвагийн "Современная научная мысль" сэтгүүлд хэвлүүлжээ. Тус өгүүллийг бичихдээ Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын местний оросуудтай биечлэн уулзаж, тэдний аман

ярилцлагыг үндэслэсэн байна. Энэ нь дан ганц Оросын тухай биш, Монголд суурьшсан буриад угсаатны амьдрал түүхтэй ч дам холбогдож байгаа юм.

2019 онд төслийн баг хамт олны хийсэн ажлыг харахад хамтарсан төслийн ажил хугацаандаа, календарьчилсан төлөвлөгөөний дагуу явагдсан бөгөөд тухайн онд хээрийн шинжилгээний ажлаар явсан байдалдаа тулгуурлан дараах дүгнэлтийг хийв.

1. *Булган аймгийн Тэшиг сумын буриадууд нь уламжлалт заншил, хэв ёсоо нэлээд гээж, орчин нөхцөлдөө уусан шингэж илүү халхжуу болсон байна. Тэд буриад гэдгээ ойлгож, мэдэрч, өөрсдийгөө таниж мэдэх гэж хичээж байгаа нь “Бага Алтаргана” наадмыг анх удаагаа орон нутагтаа зохион байгуулсан явдал болжээ. Тэшиг сумын буриадууд дээл хувцас, эдлэл хэрэглэлийн хувьд уламжлалт хэв загвараа гээсэн тул одоо цагийн Дорнод аймгийн Ага буриадын дээл, гоёйг шууд хуулбарлан хэрэглэх болсон байна. Энэ нь нэг талаас буриад гэдгээ мэдрэх, олонд танигдсан энгэртэй дээлийг авсан мэт боловч нөгөө талаар өөрсдийн язгуурын дээл хувцасаа сэргээж хэрэглэхгүй байх үндэс болж байна. Иймд аль алийг нь хэрэглэж, дэлгэрүүлэхэд анхаарах шаардлагатай байна.*
2. *Буриад нутгаас төрж гарсан эрдэмтэн мэргэд, лам нар, гэгээд хутагт цөөнгүй байдаг боловч тэдний зохиож туурвисан ном бүтээл нь толь бичиг, цөөн тооны намтар, зурхай, эм эмнэлгийн бүтээлүүд байна. Буриадын түүхийн талаар өгүүлсэн чойнжүн маягийн зохиол өнөө хэр бараг үгүй гэж хэлж болохоор байна. Иймд судалгааны найдвартай баримт болох төвөд, монгол хэлээр туурвисан сурвалж бичгийг хайн цуглуулж, эмхэтгэн судалгааны эргэлтэд оруулах нь нэн даруй шаардлагатай хийх ажил болжээ.*

2020 онд дэлхий нийтийг хамарсан цар тахал ковидын улмаас санхүүжилт зогссон хэдий боловч бид өөрсдийн боломжийн хэрээр судалгаа хийж, эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх, өгүүлэл бичих, судалгааны ажлаа нарийвчлан бичиж гүйцэтгэхэд анхаарч ажиллав. Тухайлбал:

Доктор М. Одмандах “*Батын Нямаагийн “Арандалынхан” роман дахь буриадын тухай дүрслэл, түүний онцлог*” илтгэлийг профессор Саян Жимбеевич Балдановын 85 насны ойд зориулан ОХУ-ын Буриад улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, Дорж Банзаровын нэрэмжит БУИС, Дорно дахины дээд сургууль, Буриад хэл, уран зохиолын сургууль, Буриад, эвэнк хэлний тэнхимийн хамтран зохион байгуулсан “Сибирь – ардын аман зохиол ба уран зохиолын үндэстний орон зай” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2020 оны 12-р сарын 10-11-нд интернэтээр Zoom програмаар хийж, тус хуралд илтгэв.

Их соён гэгээрүүлэгч Шарайд Жамсраны Цэвээний мэндлэсний 140 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн эрдэм шинжилгээний хурал-д “*Ж.Цэвээн ба Шинэ толь хэмээх бичиг сонины түүхийн үнэнийг тодруулах асуудал*” илтгэлийг бичиж хэлэлцүүлэв.

Монголын хөгжмийн нэрт зохиолч, найрал дууны удирдаач Гончигдамбын 90 жилийн ойд зориулсан “Г.Дарамзагд амьдрал, уран бүтээл судлал-2021” эрдэм шинжилгээний бага хуралд “*Гончигдамбын Дарамзагдын уг гарвал*” илтгэлийг хэлэлцүүлэв.

Мөн буриадын сэхээтнүүд монгол улсад тогтмол хэвлэл гаргахад оруулсан хувь нэмрийг тодруулах, түүний үнэн зөв бодит түүхийг тодруулахын тулд Жамсраны Цэвээний тухай, түүний эрхлэн гаргасан “Шинэ толь хэмээх бичиг” сонины эх бичвэрийн судалгааг шинээр хийж, тусгай бие даасан “Монголын анхны тогтмол хэвлэлийн түүхийн судалгаа” /2021/ гэсэн нэг сэдэвт бүтээлийг Ж.Цэвээний мэндлэсний 140 жилийн ойд зориулан хэвлүүлжээ.

Доктор Л. Оюунцэцэг 2019 оны 7 дугаар сарын 1-2-нд Булган аймгийн Тэшиг суманд зохион байгуулагдах “Бага Алтаргана-Тэшиг 2019” наадмыг дашрамдуулан хээрийн шинжилгээний ажлаар тус сумын буриадуудын дунд буриад үндэсний хувцасны уламжлал хэрхэн байгаа талаар тандалт судалгаа хийж, аман түүхийн мэдээлэл олж авах, наадамчин олны дунд фокус бүлгийн судалгаа хийх зэргээр материал цуглуулж, түүндээ задлан шинжилгээ хийх зорилго тавин ажилласан юм. Судлагдахуун дээрээ үндэслэн мэдээллийг боловсруулахын зэрэгцээ одоо уламжлагдан байгаа хонгоодор буриадуудын хувцасны өнөөгийн байдлыг XIX-XX зууны үед хэрэглэж байсан Хонгоодоруудын хувцастай харьцуулан үзсэнээс гадна Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Бухын хошууны хадны оршуулгаас олдсон археологийн үнэт олдвор болох “XIII зууны үеийн Язгууртны дээл”-ээр тодруулан үзэж, антропологийн зүгээс тайлбарлах, харьцуулан үзэх аргаар судлан шинжлэв. Үүний үндсэн дээр “Угсаатны зүй: Тэшигийн буриадуудын үндэсний хувцасны хадгалалт, хувиралт” сэдвээр Оросын ШУА-ийн Сибирийн салбарын хүрээлэнгийн ЭША Ц.Б.Бадма-Хандатай хамтран нэгэн өгүүллийг бичиж, төслийн хүрээнд эмхэтгэн гаргах номонд оруулахын зэрэгцээ Тэшигийн буриадуудын үндэсний хувцасны хадгалалт, хувиралт” сэдвээр илтгэл тавив. Судалгаанд хамруулан үзсэн материал дээр ажиллан харьцуулсан зэргийн судалгаа хийж илтгэл бичив.

Хээрийн шинжилгээний ажлаар аялж явахдаа байгалийн сайхан, элдэв учралууд тухай болон Тэшигийн буриадуудын аж байдал, ахуй соёл, “Бага Алтаргана” наадмын тухай товч өгүүлсэн Тэшиг тийш сэтгэл татагдана ... аян замын тэмдэглэл бичиж, нийтлүүлжээ.

Монголын буриадуудын дунд буриад хэл-аялга нилээдгүй алдуурч байгаа нь өдөр ирэх тутам анзаарагдаж буйд доктор Л.Оюунцэцэг сэтгэл чилээж явдаг эрдэмтний нэг юм. Буриадаар бичих, хэвлэн нийтлэх албан ёсны хөтөлбөр үгүйн дээр сайн дураараа өөрсдийн хэмжээнд бичиж туурвих цөөн тооны хүмүүс байдаг. Тиймээс, буриад хэл-аялгаар ярих, унших хүн болгонд зориулж Тоонтымни хүхэ шулуун, Гүүртэдэ, Хайрханаймни бэшэрэл гэсэн гурван шүлгийн түүвэр нийтлүүлжээ. Тус шүлгээрээ, буриад ардын ахуй байдал, нутаг орон, уул ус, төл мал, янаг амрагийн шүлгүүд зонхилох бол магтаалууд мөнхүү байгаа нь хэл сурах, дадах хүмүүст нэмэр болно хэмээн үзсэн бөгөөд судлаач сонирхогчид таашаан хүлээн авсан бүтээл болжээ:

Хойч үеийнхэн болоод уншигч олонд буриадын түүхэн хүмүүсийн алдар гавьяаг таниулан мэдүүлэхийн тулд Сергей Бахлаевын бичсэн “Молон багш”, “Балжин хатан” түүхэн домгийг монгол хэлний буриад аялгаас халх аялганаа хөөн хөрвүүлэв.

Мөн хэл бичгийн шинжлэх ухааны доктор, профессор Г.Гантогтох багштаны хөрвүүлсэн “Монголой нюуса тобшоон” номны редактороор ажиллав. Тус номны хөрвүүлэг нь их онцлогтой бөгөөд мартагдаж байгаа буриад хэлний олон аялгаар хөрвүүлэгдсэнээрээ хэл судлаач, буриад хэлийг харьцуулан үзэгч, сонирхогч нарт гарын авлага болохуйц бүтээл болсон юм.

Монгол Улсад орж ирсэн буриадуудын нүүдэл суудал дахь амьдралыг ч сонирхон судалж, Өвөрбайгалын хязгаараас Монголд Улсад дагаар орж ирсэн зарим буриадуудын баатарлаг гавьяаны тухай сурвалж судалгаа хийв. Үүнд

1. 1939 оны хавар Японы милитаристууд Тусгаар тогтносон БНМАУ-ын Зүүн өмнөдийн дархан хилийг Халх голын чиглэлээр зарлаагүй дайн дэгдээхэд Ага нутгаас монгол руу нүүж ирэгсдийн элгэн садан болох Дорнод аймгийн Баяндун сумын бага сургуулийн 14-22 насны 16 буриад басгад өөрийн сайн дураар эх орноо хамгаалахаар дайнд мордож, цэргийн эмнэлгийн арын албанд сестра, галч, угаагч, индүүдэгч хийснээс гадна дайны фронтоос шархтан цэрэг авчирах зэргээр ажиллаж байв. Дайн дуусахад тэд 2 нөхдөө алдан буцсан судалгааны явцад ил тод, үнэнийг өчин гаргасан ба мөн 80 жилийн түүхэн ой болоход тэдгээр баатарлаг охидын тухай нэгээхэн дурсгалын хөшөө, самбар үгүйн хирээр түүхийн аливаа номонд багтахгүйгээр мартагдаж өдий хүрсэн байна. Энэхүү аюумшигт түүхийн жимээр 2 жилийн туршид орон нутагт суух ахан дүүс, Улаанбаатар нийслэлд амьдрах эдүгээ 96 насны сүүдэр зооглож суугаа ахмад дайчин Ц.Чимидцэрэн гуай зэргийг сураглан олж, тэд бүхнээс аман түүхийн сурвалж мэдээ цуглуулж бүтээсэн түүхэн зохиол юм. Мөн 16 охидын төрсөн нутаг Дорнод аймгийн Баяндун сумын Адуун чулуун гэдэг газар “Хатан зоригтон-1939” чулуун хөшөө босгож алдар гавьяаг нь мөнхжүүлэв
2. Агын тойргийн Таптаанай нутгаас гаралтай дэд хурандаа Чимиддоржийн Аюушийн 1939 оны Халх голын дайн, 1945 оны чөлөөлөх дайнд эх орноо хамгаалан оролцож явсан түүхэн замналаас хөрөг дурсамж бичив.
3. Агын тойргийн хүдэнтэ (Сүдэнт) нутгаас гарвалтай Бүмбэй баряашын эди шэди хөрөг дурсамж бичив.

2020 оны 8-р сард хийхээр төлөвлөж байсан эрдэм шинжилгээний хурлыг ямар нэгэн хэлбэрээр зохион байгуулах боломж гараагүй бөгөөд 2022 оны эхний улиралд төслийн санхүүжилт орж ирсэн даруйд бид өдөр товлон хурлын удирдамж, зарыг шинэчлэн гаргаж, Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэн, Буриад судлалын академитай хамтран олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2022 оны 4 сарын 2-нд ХЗХ-ийн номын санд танхим цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулав. Хуралд 3 улсын 16 эрдэмтэн судлаач илтгэл хэлэлцүүлж, санал дэвшүүлэв.

Монгол, Орос хоёр улсын төслийн багийн гишүүд Монгол Улсад уулзалдаж төслийнхөө ажлаар санал солилцон, хамтарсан судалгааны эмхэтгэл гаргахаар төлөвлөж байсан нь цар тахлын улмаас өөрчлөгдсөн тул судлаачид урьд өмнө хэвлүүлсэн өгүүлүүдээ эмхэтгэн нэгэн судалгааны эмхэтгэл гаргав. Учир нь эдгээр өгүүлэл нь хэдийгээр өмнө нь янз бүрийн сэтгүүл хэвлэлд нийтлэгдсэн боловч тэр бүр олны хүртээл болж чадаагүй, голчлон мэргэжлийн хүрээнд тарсан тул аль болох энгийн уншигч олон түмэнд хүргэхийг бодолцож, дахин нэгэн доор эмхэтгэн хэвлүүлж байгаа юм. Ингэснээр бидний ажлын үр дүнг бодитой үнэлэх, өгүүллийг уншиж, танилцаж, цаашид гүнзгийрүүлэн судлан үзэх боломжийг хангана гэж үзэж байна.

Төлөвлөгөөт бус ажил

Төслийн ажлын календарьчилсан төлөвлөгөөнд тусгаагүй боловч томилолтоор ажиллах явцдаа нэмж судлагдахуун эрэлхийлэн шинжилсний үр дүнд төслийн судалгаанд

холбогдох чамгүй ажлуудыг манай судлаачид хийсэн юм. Тухайлбал, доктор Л.Оюунцэцэг:

1. “ДЭЭЛТЭЙ МОНГОЛ” наадмын үйл явц дахь угсаатны зүйн эх хэрэглэгдэхүүн судлал (2019.07.10.)2. “ЁОХОР ХАТАР-2019” бүжгийн наадам (2019.07.17-18)-ын үйл явц дахь эх хэрэглэгдэхүүн судлал болон эрдэм шинжилгээний хуралд “Буриад үндэсний хувцас, бэлгэдэлзүйн онцлог” илтгэл тавьж, илтэлүүдийн эмхэтгэлээр ном гарган ажиллав .

“Халх голын түүхэн ялалтын 80 жилийн ой”-г тохиолдуулан хийсэн судалбар ажлууд: Дайнд оролцож явсан 16 буриад басгадын тухай түүхэн сэдэвтэй уран сайхны кино зохиол бичжээ (нууцын зэрэглэлтэй),- Мөн баримтат кино зохиол бичсэн (нууцын зэрэглэлтэй),- 1939, 1945 оны Халх голын дайнд Дэд хурандаа Чимиддоржийн Аюушийн оруулсан намтар, түүх (найраглал) бичиж, хэвлүүлсэн, - Халх голын дайнд оролцсон 16 буриад басгадын гэгээн дурсгалд зориулсан “Чулуун хөшөө”-г 16 басгадын төрсөн нутаг Дорнод аймгийн Баяндун сумын Адуунчуулуун хэмээх газарт 2019.08.27-ны өдөр босгож, хөшөөний нээлт хийсэн. - “Бэрхийг туулсан басгад” түүхэн сэдэвт ном бичиж, Интер номын дэлгүүрт номын хуримыг 2019.09.04-ний өдөр хийж, олны хүртээл болгосон. - БХЯ-наас явуулж буй цуврал нэвтрүүлгийн ТВ бичлэгт орж, ярилцлага өгсөн. - МҮОНРТВ-ийн MN2 сувгаар, дайнд оролцож явсан 16 буриад басгадын түүхэн замнал тухай яриа өгсөн зэрэг ажлуудыг хийжээ. Төслөөс гадуурх эдгээр ажил нь буриад судлалын холбоотой хийсэн ажил тул энэхүү тайланд оруулсан болно.

ТОМИЛОЛТООР АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Төслийн гүйцэтгэгчид тайлант хугацаанд ОХУ-ын Буриад улсад 2 удаа, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шинэхээн буриадад 1 удаа, Монгол Улсын Булган аймгийн Тэшиг суманд 1 удаа тус тус төслийн томилолтын зардлаар, Монгол Улсын Хэнтий аймагт 1 удаа, Хөвсгөл аймагт 1 удаа, Дорнод аймгийн Баяндун, Цагаан овоо, Баян-Уул суманд урт богино хугацаагаар 5 удаа өөрсдийн хувийн зардлаар явж судалгаа, ажиглалт хийжээ. Доор жишээ болгож, хоёр удаагийн томилолтын удирдамж, тайланг үзүүлэв.

Удирдамж

2019.06.27.

Зорилго:

“Орос, Монгол, Хятад гурван улсын буриад угсаатны аман зохиол, аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралтын судалгаа” хамтарсан төслийн хүрээнд хээрийн шинжилгээгээр судлагдахуун хайх, цуглуулах ажлын бүрдүүлэлт хийхийн тулд 2019 оны 7 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд Булган аймгийн Тэшиг суманд зохион байгуулагдах буриад ардын зан заншил, соёл урлаг, спортын “БАГА АЛТАРГАНА-2019” наадмын үйл ажиллагааг судалгааны гол объект болгон ажиллахад гол зорилго оршино.

Судалгааны ажлаар явж ажиллах 2 эрдэмтэн:

- Одмандах М. (Хамтарсан төслийн гүйцэтгэгч, доктор, дэд проф),
- Оюунцэцэг Л. (Хамтарсан төслийн гүйцэтгэгч, доктор) нар болно.

Ажлын чиглэл:

- Тэшиг сумын буриадуудын угсаа гарвал,
- хэл яриа, түүний хэрэглээний соёл,
- аман соёл, түүний төрөл зүйлүүд,
- хувцас, тэдгээрийн онцлог шинж, хэрэглээний байдал,
- буриад угсаатны биет бус соёлын өвийн хадгалалт, хамгаалалт ... г.м.

Ажлын үр дүн:

- Булган аймгийн Тэшиг суманд оршин суух Эхирэд, Булагад, Хонгоодор буриадуудын өв соёлын байдлыг тогтоон үзэх,
- Соёлын ижилсэл болоод ондоошлыг харьцуулан судлах,
- Судлагдахууныг судалгааны эргэлтэнд оруулах, сурталчилах,
- Хээрийн шинжилгээний ажлын тайлан бичиж өгөх

Хугацаа: 2019.06.29-нөөс 2019.07.04-ны өдрүүдэд явагдана.

Жич: Төсвийн задаргаа 1 хуудас материалыг хавсаргав.

Удирдамжийг зөвшөөрсөн:

ХАМТАРСАН ТӨСЛИЙН УДИРДАГЧ

/Д.НАРАНЦЭЦЭГ/

Батлав. Төслийн удирдагч

Д.Наранцэцэг

ТӨСВИЙН ЗАДАРГАА

Д/д	Ажлын нэр	Тоо хэмжээ	Зардал	Тайлбар
1.	Замын зардал: - Бензин - Жолоочийн хөлс	1600 км*12 л= 133 л түлш = =	133л*1940₮= 258.600₮ = =	
2.	Эрдэмтдийн: - Зочид буудал, хоол унд	2 судлаач, 6 хоног 1х*36,0*2 хүн	 6х*58,0=432,000	
	НИЙТ ТӨСӨВ		690,600₮	

Төсөв зохиосон:

/Л.Оюунцэцэг/

Төсвийн задаргаа хянасан:

/Н. Оюумаа/

“ОРОС, МОНГОЛ, ХЯТАД ГУРВАН УЛСЫН БУРИАД УГСААТНЫ
АМАН ЗОХИОЛ, АМАН СОЁЛ, УГСААТНЫ СОЁЛЫН ХАДГАЛАЛТ,
ХУВИРАЛТЫН СУДАЛГАА” ХАМТАРСАН ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧ,
ДОКТОР Л.ОЮУНЦЭЦЭГИЙН
БУЛГАН АЙМГИЙН ТЭШИГ СУМАНД АЖИЛЛАСАН
АЖЛЫН ИЛТГЭХ ХУУДАС

2019.07.08.

Тус хамтарсан төслийн хүрээнд Монгол Улсын баруун хойт зүгийн нутгаар оршин суух буриадуудыг судлах явдал бөгөөд Булган аймгийн Тэшиг суманд амьдран суудаг эхирэд, булгад, хонгоодор угийн буриадуудын амьдралын хэв маяг, түүний оршин буй ахуйг тандахаар ажлын томилолт авч 2019 оны 6 сарын 29-нөөс 7 сарын 4-ны өдрүүдэд, 6 хоногийн хугацаатайгаар тус хамтарсан төслийн гүйцэтгэгч, доктор М.Одмандах бид хоёр хамт явж ажилласан бөгөөд судалгааг тус тусын чиглэлээр хийж гүйцэтгэсэн болно.

Тэшиг суманд “Бага Алтаргана-Тэшиг 2019” наадам 2019 оны 7 сарын 1-2-ны өдрүүдэд зохион байгуулагдахаар зарлагдсаны дагуу монгол нутагт суух баруун буриадуудын уг гарвалын тасархай, тэдний төрөл садангуудын дунд фокус бүлгийн судалгаа, аман түүхийн ярилцлага хийв. Тус наадмын үйл ажиллагаа товлосон өдрөө явагдсан бөгөөд наадамд цугларсан ард зоны ерөнхий байдалд зураглал хийж, зарим хүмүүстэй буриад хувцас өмсгөл, гоёл зүүсгэлийн талаар ганцаарчилан уулзах, яриа авах, тодруулга хийх зэргээр ажилласны дээр наадамд ирсэн зон олны дундаас онцгойрсон, сонирхол татсан хувцасны зургуудыг буулгаж баталгаажуулан тэмдэглэл хийв. Мөн тус суманд суурин амьдарч байгаа буриад зоны ахуйн байдал-орон гэр, гэр сууц, хашаа саравчны байдалтай танилцан, заримийг баримтжуулсан зураглал хийж авав.

“Бага Алтаргана-Тэшиг 2019” наадмыг тохиолдуулан ОХУ-ын Захаамини, Түнхэн районы албаны төлөөлөгчид болон ахан дүүс нараас ирж оролцсон нь наадам олон улсын шинж чанартай болсноос гадна Орос-Монголын хилийн дээсний хоёр талд оршин суух хамаатан садны тасархайнууд “Эв мод”-оо нийлүүлж баяраа эхэлсэн нь сонирхол татаж байлаа. Наадмаар буриад сурын харваа, буриад бөхийн барилдаан, морь уралдаан, сээр хугалах хүч тамирын тэмцээнүүд болсноос гадна эрдэм шинжилгээний хурал явагдаж, хурлын шүүгчээр тус төслийн гүйцэтгэгч, доктор М.Одмандах Л.Оюунцэцэг нар ажиллав.

Эрдэм шинжилгээний хуралд 5 хүн илтгэл хэлэлцүүлсэн ба илтгэгч нар мэргэжлийн чиг дагуу биш ч буриад ахуй, амьдралын талаар ярьж байлаа. Жишээ нь: Ц.Найдан нь инженер мэргэжилтэй боловч “Сонгоол түмэн мину” гэсэн угсаа гарвалын уг сурвалжийн тухайд өөрийн судлагдахууныг илтгэсэн бол Ерөнхий боловсролын сургуулийн 11 дүгээр ангийн төгсөгч-сурагч Ч.Отгон-Эрдэнэ “Орон нутгийн буриад үндэстний түүх соёл, ёс заншил, өв уламжлал” гэсэн өргөн хүрээтэй асуудлаар илтгэл тавив. Мөн тус Тэшиг сумын уугуул аав, ээжтэй байсан Л.Гэрэлтуяа хэдийгээр энд амьдардаггүй ч аавынхаа ажил байдлын намтар түүхийг “Нэгэн буриад хүнийг танилцуулах нь” нэрийн дор ярьж хэлсэн нь сонирхол татаж байлаа. Хэдийгээр илтгэл,

элдэв бичиг цаас бэлдээгүй ч “Х.Чойбалсангийн эмч явсан аавынхаа тухай” ийнхүү хүүрнэсэн нь буриад хүн Төрийн том албанд хүчин зүтгэж ирсэн алдар нэр хичнээн хүнд хэцүү байсныг дурсан ярьсан юм. Улаанбаатар хотын төлөөлөгч Н.Чойбалсан (барилгын инженер) тэрээр, буриадуудын хэрэглээнд байсаар ирсэн малын хашаа хороо, аргалын хашлага-заваали болон ахуйн хэрэглээний үйсэн түйс, тэвш г.м зүйлсийн хэрэглээ тухай танилцуулав.

Мөн ОХУ-ын Захаамини нутгаас ирсэн төлөөлөгч Валерии, хонгоодор ясны буриад угсаа гарвалын талаар, хамаатан садангуудаас нь монголд нүүж ирсэн талаарх илтгэл тавьсан нь сонирхолтой байлаа. Эдгээр судалгааны бүтээлүүдээс ажиглахад, Дорнод зүгийн буриадуудын болоод Тэшигийн буриадуудын ахуйн хэрэглээний зүйлс зарим талаараа адил байх бол бас өөр талаараа ондоошлыг харуулах нь ажиглагдаж байлаа.

Төслийн гүйцэтгэгч, доктор М.Одмандах буриад сурын харваанд оролцож түрүүлэв. Л.Оюунцэцэг миний бие “Буриад үндэсний хувцас”, “Дангина” тэмцээнүүдийг шүүж, өөрийн судалгаанд хэд хэдэн сурвалжийг тэмдэглэн авсан ба гоо басгадын тэмцээн, буриад үндэсний хувцасны уралдаан амжилттай явж өндөрлөв. Уралдаанд оросын буриадын нэг оролцогч оролцож, 3 дугаар байрт шалгарав. Буриадаар ярих, ойлгохдоо тааруухан байсан учраас асуултанд сайн хариулж чадаагүй юм. Соёл урлагийн олон арга хэмжээ явагдсаны дотор буриад ардын дуу, зохиолын дуу, “Буряадаараа хөөрөлдэе” аман зохиолын дээж домог яриа зэргээр уралдав.

Мөн Тэшиг сумын байгаль орчин, байгалийн сайхантай танилцан, байгаль-хүн хоёрын хүйн холбооны талаар ажиглалт хийв. Ерөнхийлөн авч үзвэл “Тэшигийн буриад” гэж алдаршсан тус буриадуудын “Соёлын өвөрмөц ба цогц чанар”-ын талаар тандалт судалгаа хийсэн болно.

Эцсийн үр дүнд эдгээр олон соёлууд харилцан адилгүй оршиж байгаа талаар экологийн нөхцөл байдал, сэтгэл зүйн учир холбогдол, туулж өнгөрүүлсэн харилцан адилгүй түүхийн үндсэн шалтгаануудыг тодруулан тайлбарлахад судалгааны гол зорилго оршино.

“БАГА АЛТАРГАНА-ТЭШИГ 2019” наадмаас хийсэн судалбар зургууд





Илтгэх хуудас бичсэн:

Хамтарсан төслийн гүйцэтгэгч

Л.Оюунцэцэг

**ОХУ-ЫН БУРИАД УЛСЫН УЛААН-ҮД ХОТОД
АЖИЛЛАХ УДИРДАМЖ**

СУИС-ийн СУСХ ба ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвд судлалын салбартай хамтран ШУТС-ийн дэмжлэгээр 2018- 2020 оны хооронд хэрэгжүүлж буй “Орос, Монгол,Хятад гурван улсын буриад угсаатны аман зохиол, аман соёл, угсаатны соёлын хамгаалалт, хувиралтын судалгаа” төслийн 2019 оны төлөвлөгөөт ажлын хүрээнд тус төслийн судлаач доктор О.Баттуяа, доктор Л.Оюунцэцэг нар Улаан-Үд хотод 10- р сарын 20-с мөн сарын 26-ны хооронд 5 хоногийн хугацаатай ажиллана. Мөн томилолтын хугацаанд судлаачид Улаан-Үд хотын архивт хадгалагдаж буй буриад нарын тухай ямар материал хадгалагдаж буйг судлах, мөн 10 сарын 23-24-нд болох “Монгол угсаатны хэл соёл” эрдэм шинжилгээний хуралд монголчуудын дунд хадгалагдаж буй нутгийн аялгуу, ахуй соёлын талаар илтгэл тавьж хэлэлцүүлнэ.

БОЛОВСРУУЛСАН:	О.Баттуяа
ЗӨВШӨӨРСӨН:	Д.Наранцэцэг

Замын зардал:

№	Чиглэл	Үнэ	Хүний тоо	Дүн
1.	Улаанбаатар- Улаан-Үд	83600 төг×2	2 хүн	167200 төг
2	Улаан-Үд – Улаанбаатар	4900 ¹ руб (207760 төг)	2 хүн	9800 руб (415520 төг)
3	Нийт			582720 төг

Томилолтын зардал:

№	Ажиллах газар	Хугацаа	Хүн/ өдөр	Зардал	Дүн
1	Томилолт	Х/20-Х/27	2/5	10×20\$	200\$ (535400 ₮)
2	Зочид буудал	5 хоног	2/5	10×500руб(212000₮)	212000₮
3	Нийт				747400₮

Томилолтын нийт зардал: 1.330.120 төг

¹ 2018 оны 10 сарын 15-ны өдрийн рубль ба төгрөгийн ханшаар (1р=42,40 ₮) тооцов.

“Орос, Монгол, Хятад гурван улсын буриад угсаатны аман зохиол,
аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралтын судалгаа” сэдэвт
хамтарсан төслийн гүйцэтгэгч, доктор Л.ОЮУНЦЭЦЭГИЙН
ОХУ-ЫН УЛААН-ҮД ХОТ ДАХЬ ДОРНО ДАХИНЫ
ГАР БИЧМЭЛ БА МОДОН БАРЫН НОМЫН АРХИВТ БОЛОН
БУРИАДЫН ИХ СУРГУУЛЬД
АЖИЛЛАСАН АЖЛЫН ИЛТГЭХ ХУУДАС

2019.11.15

Тус хамтарсан төслийн ажлын хүрээн дэх төлөвлөгөөт ажлаар ОХУ-ын Буриад Улсын нийслэл Улаан-Үд хот дахь Базар Барадины нэрэмжит Номын сангийн гар бичмэл, модон барын архивт сууж, угсаатны зүйн эх хэрэглэгдэхүүн цуглуулах, мөн БГУ (Буриадын Их сургууль) дээр зохион байгуулагдах Олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж оролцох юм.

2019 оны 10 дугаар сарын 20-27-ны өдрүүдэд 2 чиглэлээр дараах ажлуудыг гүйцэтгэсэн болно.

Нэг: Дорно дахины гар бичмэл, модон барын номын төвийн архив

Угсаатны зүйн судалгааны эх хэрэглэгдэхүүн цуглуулахаар Базар Барадины нэрэмжит Номын сангийн гар бичмэлийн фондоос: ЦВРК МБТСОРАН. ЛАФ №18. Оп 1. Д 21; ОАФ №1928; ЛАФ. 17. Оп 1. Д 319; 1829; ОАФ №1915 дугаар бүхий гар бичмэл баримтууд, хувцасны хээ угалз, үс засалтын хэв төхөл зэргийг дүрсэлсэн гар зураг болон буриад үндэсний хээ бүхий гоёл чимгийн гэрэл зургийн материалуудыг хуулбарлан авсан болно. Хуулбарлан авсан бичиг баримтын нийт төлбөр 3060 рубль болж, нэхэмжлэл ёсоор төлбөрийг төлөв (Төсвийн задаргаа: Хавсралт 1).



Хоёр: Улаан-Үд хотын түүхийн музей

Улаан-Үд хот байгуулагдсан цагаас эхлэн буриад ард зоны ахуйн хэрэглээн дахь эд өлгийн зүйлс хэрхэн байсан

талаар сурвалж судалгаа хийхээр “Улаан-Үд хотын түүхийн музей” үзэв.

Музейд, Нерчинский договор (1346 августа 27), буриадудын хэрэглэж байсан гэр ахуйн үйсэн савнууд, төрөл зүйлийн модон тэвш, цогийн индүү, хэл хуур гэх мэт эд хөгшил хадгалагдаж байхаас гадна тооробшо 2 ш, буриад үндэсний эрэгтэйн дээл 2 ш, эмэгтэйн дээл 2 ш, басган дээл 1 ш буюу бүгд 5 ширхэг дээл байгааг олж үзэв (зураг авах эрхгүй). Тасалбарын үнэ 60 рубль төлөв.

Гурав: Буриад Улсын Үндэсний музей

Тус музейн үзэсгэлэнд байгаа угсаатны зүйн эх хэрэглэгдэхүүн болох буриад дээл хувцасны зүйлийг үзэж, шинээр гарсан “Бурятский традиционный костюм” катологи худалдан авав. Үнэ 2000 рубль, музей үзэх тасалбарын үнэ 160 рубль. Бүгд 2160 рубль.



Дөрөв: Буриад Улсын Их Сургууль.

БГУ (Бурятский государственный университет)-ын Буриад, эвенк хэлний тэнхимийн зүгээс, тус сургуулийн кафедрын эрхлэгчээр ажиллаж байсан эрхэм багш, доктор, профессор Цей-Жаб Цыдыповын мэндэлсний 100 жилийн ойн баярт зориулсан “Олон улсын эрдэм шинжилгээний “Языки и литературы монгольских народов: теория и практика” сэдэвт хуралд “Буриад судлалын академийн үүсэл, хөгжил” сэдвээр үндсэн хуралдаанд илтгэл тавьж (*илтгэлийг хавсралтаар*) хэлэлцүүлэв. Илтгэлийн хэвлэлийн үнийн төлбөрт 3100 рубль төлөв. Мөн хурлын үйл ажиллагаанд амжилт хүсэн Цыдыпов Цей-Жаб Цыдыповичын номын санд болон Буриад хэлний тэнхимд номын багцаар бэлэг барив. Мөн БНЦ-ын Эрдэмтэн нарийн бичгийн дарга Гүнсыма болон ЭШ-ний ажилтан Дарима Жамсуева, Бадма-Ханда Цыбикова нарт бэлэг барив. Мөн хүндэтгэлийн хүлээн авалтанд ирсэн зочдод номын дээжээс бэлэглэв.

ОХУ-ын Буриад Улсын нийслэл Улаан-Үд хот дахь
Базар Барадины нэрэмжит Номын сангийн гар бичмэлийн архиваас
эх сурвалжийн баримт хайх, Олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавих зэрэгт
зарцуулсан төсвийн задаргаа

2019.11.15.

	Ажлын нэр	Хугацаа	Зардал	
			рубль	төгрөг
1.	Улаанбаатар-Улаан-Үд (вагоноор)	2019.10.20-21.	-	78,750
2.	Улаан-Үд-Улаанбаатар (автобусаар)		1,800	77,040
3.	Байрны төлбөрт	5 хоног	5*700=3,500	149,800
4.	Улаан-Үд хотын түүхийн музей	2019.10.21.	60	2,568
5.	Буриад Улсын Үндэсний музей	2019.10.24	160	6,848
6.	Базар Барадины нэрэмжит Номын сангийн гар бичмэлийн архиваас: ЦВРК ИМБТСОРАН. ЛАФ №18. Оп 1. Д 21; ОАФ №1928; ЛАФ. 17. Оп 1. Д 319; 1829; ОАФ №1915 цолны дуудлага, буриад үндэсний хээ болон ахуйн холбогдолтой гэрэл зургийн материалыг хуулбарлан авахад	2019.10.21-23.	3,060	130,968
7.	Доржи Банзаровын нэрэмжит Буриадын Их Сургуулиас зохион байгуулсан: Доктор, профессор Цей-Жаб Цыдыповын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан “Языки и литературы монгольских народов: теория и практика” хуралдаанд тавьсан илтгэл хэвлэлтэнд	2019.10.24-26.	3,100	132,680
	Талын дүн		11,680	578654
	Бүгд дүн			578654

/1 рубль=42,80 төгрөг/

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ХАМТАРСАН ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ОЮУНЦЭЦЭГ,
Түүхийн ухааны доктор (Ph.D)

ИЛТГЭХ ХУУДАС

№	Огноо: 2015.04.06	Албан тушаал	Овог, нэр	
1	Илтгэх хуудас бичсэн:	СУСХ-ийн ЭНБД	Дамбийхорлоо НАРАНЦЭЦЭГ	
2	Илтгэх хуудсанд хамрагдах нутаг дэвсгэр:	Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвөд, Буддын шашин судлалын хүрээлэн		
3	Илтгэх хуудсанд хамрагдах хугацаа:	2018.09.07-2018.09.10		
4	Хийгдсэн ажлууд:	Олон улсын хуралд оролцох		
5	Томилолтын удирдамжийн гүйцэтгэл	Хангалттай	Хангалтгүй	Хувь
		+		100
6	Тайлан: /ажилласан байгууллага, уулзсан хүмүүс, уулзалтын байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл/	<p><u>2018.09.07-ны өглөө 05 цагт</u> Улаанбаатараас 21-68 УБЭ Тоёота Харриер маркын машинаар гарч, үдшийн 20 цагт ОХУ-ын Буриад Улсын Улан-Үдэ хотноо хүрч Монреаль зочид буудалд байрлав.</p> <p><u>2018.09.08-ны өдөр 09-17 цаг</u> хүртэл хурлын хөтөлбөр дагуу Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвөд, Буддын шашин судлалын хүрээлэнд очиж бүртгүүлэн, хуралд оролцож, “Буриадын эрдэмтэй лам Галвабадраданагийн орчуулсан Бурхан багшийн намтарт хийсэн шинжлэл” илтгэлийг хэлэлцүүлэв.</p> <p>18 цагт Хүлээн авалтын зоогт орж, түүний дараа Еле ринбүчийн дацанд очиж гороо эргэв.</p> <p><u>2018.09.09-нд</u> Буриад дахь гар бичмэл ба модон барын төвд сууж, намтар зохиолын холбогдолтой судар номын каталоги шүүрдэн үзэж, зарим нэгэн материалыг хувийн судалгаанд хуулбарлан авав.</p> <p><u>2018.09.10-нд өглөө 8:30 минутад</u> буудлаасаа гарч, замдаа Иволгын дацангаар орж Буриадын хамба лам Дамба Аюушеевын тавьсан хүсэлтийн дагуу ламтанд бараалхаад, тэндээсээ шууд Улаанбаатарт хүрч ирэв.</p>		
7	Үр дүн:	1. “Бичгийн өв ба монголчуудын түүх соёлын чухал асуудлууд” олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэв.		
8	Цаашид авч хэрэгжүүлэх	1. Орос-Монголын хамтарсан төслийн ажлыг эрчимжүүлэх 2. Хүрээлэнгийн залуу судлаачийг гадаадад болж буй олон улсын		

	ажлын санал:	хуралд аль болох оролцуулж, мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх		
9	Санал хэрэгжүүлэх хугацаа:	1. 2018-2020		
10	Хавсаргасан материал:	Хавсралтын тоо: 1	Хэлбэр: цаасан танилцуулга	
		Буудлын баримт		
11	Илтгэх хуудсыг үнэн зөв бөглөсөн:			
12	Илтгэх хуудсыг хянасан:			
13	Илтгэх хуудастай танилцсан:			

ДҮГНЭЛТ

Буриад монголчуудын тухай судалгааны эх хэрэглэгдэхүүнийг Монгол Улсад 1970-1990 он хүртэлх хугацаанд ШУА-ийн хүрээлэнгүүд, их, дээд сургуулийн эрдэмтэд олж цуглуулсан хэдий ч зарим нь эрдэм шинжилгээний эргэлтэнд ороогүй, эх материал нь хадгалалтын буруугаас болж устах, дахин сэргэхээргүй болж үгүй болсон зэрэг шалтгааны улмаас үрэгдэж, олон нийтэд төдийлөн хүртээмжтэй биш байна. Иймд энэ цаг үеэс хойших шинэ цагт буриад монголчууд өөрсдийнхөө түүх, соёлын өвийг хэрхэн хадгалж, үлдээж, хөгжүүлж байгааг эргэн судлах, шинэ технологи, хөгжлийн хандлагыг ашиглан эх хэрэглэгдэхүүнийг шинэ маягаар судлах, цуглуулах, бусад эх хэрэглэгдэхүүнтэй харьцуулан дүгнэх шаардлага нийгэмд үүсээд байсан юм.

Өдгөө ОХУ, Монгол, БНХАУ-д улсад монголчуудын угсаатны соёл, аман зохиол, зан үйлийн судалгаа эрчимтэй хийгдэж эхэлж байна. Гэвч өнөө хэр нь монгол угсаатны голлох нэгэн бүлэг болох буриадуудын угсаатны соёл, ялангуяа аман соёлын уламжлал, угсаатны /бөө мөргөл хийгээд буддын/ загварчлал, прагматик-ашиглалт, эх хэлний уламжлалыг дамжуулагчдын бүтэц, хувьслын талаас нь судлаагүй байна. Иймээс Буриадын аман соёл, угсаатны онцлог шинжийг судлан тодруулж, уламжлалыг хадгалахад энэ төсөл нь чиглэж ажилласан юм.

Монгол, Орос, Хятад улсад амьдран суудаг буриад угсаатны бүлгийн аман соёлын үндсэн эхүүдийг хадгалагдаж ирсэн байдал болон хувирал өөрчлөлтийн харьцуулсан судалгаа хийх, буддын болон бөө мөргөлийн уламжлалыг угсаатны зүйн талаас нь судалж, угсаатны цөөнх болсон буриадын соёл уламжлалыг хадгалахад хувь нэмэр оруулахын тулд бид энэ төслийг эхлүүлсэн. Учир нь буриадууд нь монгол угсаатны нэгэн томоохон бүрэлдэхүүн, бие даасан овог бөгөөд тэд түүхийн урт хугацаанд ОХУ, БНХАУ, Монгол гэсэн гурван гүрэнд тасран суусан, угсаатны томоохон бүлэглэл болохын хувьд тэдний түүх, угсаатан, ёс заншил, аман зохиол, хэл соёл, утга урлаг, эдийн соёл зэргийг багтаасан цогц судалгаа зайлшгүй хийх шаардлагатай болж байна. Орчин үеийн гадаадын болон дотоодын судалгааг харьцуулан судлахаас аман зохиолыг угсаатан зүйтэй холбон судлах нь илүү үр дүнтэй, өгөөжтэй судалгааны арга болж байгаа юм. Олон улсад монгол судлал нь ерөнхийдөө цогц нэгдмэл байдалд шилжиж байгаа өнөө цагт Орос, Монгол, Хятадын буриадуудын уламжлалыг хадгалах, хамгаалах, хувилах системчилсэн аргыг олж нээх шаардлага тулгарч байна. Үүний тулд гурван улсын буриад угсаатны соёл нэгдмэл байна уу, өөр болж хувирч уу гэдгийг тогтоох асуудал бидний энэ удаагийн төслийн гол зорилго байсан юм.

Дээр өгүүлсэн зорилго, зорилтын хүрээнд ажилласны үр дүнд бид дүгнэлтэд хүрлээ.

1. Монгол улсад суугаа буриадуудын уламжлал, соёл нь цагийн эрхээр хувирч байгаа хэдий боловч сүүлийн 30 орчим жилд сэргээх, хөгжүүлэх, хадгалах гэж тал талдаа анхаардаг болжээ. Үүний нэг жишээ нь Монгол Улсаас эхлэн өнөөдөр олон улсын хэмжээнд зохиогдох болсон Алтаргана наадам юм. Тус наадам бий болсноор буриадуудын ухамсар сэтгэлгээнд уламжлалт соёлоо гэсэн хандлагыг бий болгож, улмаар үгүй болох эрсдэлтэй соёл, уламжлалаа сэргээх, хадгалах үзэгдэл нийт

буриадын дунд эрчимжиж байна. Тухайлбал, Булган аймгийн Тэшиг суманд болсон “Бага Алтаргана-2019” наадмын үеэр хийсэн гүймэг судалгаанд тулгуурлан соёлын хувиралт, хадгалалтын ярихад уламжлалт заншил, хэв ёсоо нэлээн гээж, орчин нөхцөлдөө уусан шингэж илүү халхжуу болсон байна. Тэд буриад гэдгээ ойлгож, мэдэрч, өөрсдийгөө таниж мэдэх гэж хичээж байгаа нь “Бага Алтаргана” наадмыг анх удаагаа орон нутагтаа зохион байгуулсан явдлаас харагдаж байлаа. Тэшиг сумын буриадууд дээл хувцас, эдлэл хэрэглэлийн хувьд уламжлалт хэв загвараа гээсэн тул одоо цагийн Дорнод аймгийн Ага буриадын дээл, гоёлыг шууд хуулбарлан хэрэглэх болсон байна. Энэ нь нэг талаас буриад гэдгээ мэдрэх, олонд танигдсан энгэртэй дээлийг авсан мэт боловч нөгөө талаар өөрсдийн язгуурын дээл хувцасаа сэргээж хэрэглэхгүй байх үндэс болж байна. Иймд аль алийг нь хэрэглэж, дэлгэрүүлэхэд анхаарах шаардлагатай юм.

3. ОХУ-ын буриадууд буриад хэл аялгаараа төдий л өөр хоорондоо ярьдаггүйгээс эх хэл, соёл уламжлалдаа бахтай эрдэмтэн сэхээтэн зэрэг цөөн хүмүүсийн дунд л буриад хэл аялгуу уламжлан үлджээ. Гэвч сүүлийн жилүүдэд мөн л буриад хэл аялгуугаа сэргээх, уламжлуулах олон арга хэмжээ зохиож байгаа нь сайшаалтай бөгөөд үүнийг цаашид тасралтгүй эрчимжүүлж гэмээнэ сая өөрсдийн хэл аялгаа хадгалж, хамгаалж авч үлдэж чадах юм.
4. БНХАУ-ын буриадууд хэл аялгаа нэлээн хадгалсан, гэр зуураа буриад аялгаараа ярьдаг, монгол дунд сургуульд ч буриад хэлний хичээл 2019-2020 оны хичээлийн жил болтол орж байсан нь буриад аялгаа хадгалахад чухал ач холбогдолтой байна. Тэд хэдийгээр тооны хувьд харьцангуй цөөн хүн амтай боловч буриад үг хэллэг, хувцас хэрэглэл, угийн бичиг, овог аймаг, эцэг эхийн удам судрын нэрээ марталгүй хадгалж ирсэн, буриадын тоонот тайх зан үйл, мэнгэ андалдах ёс уламжлал, буриад сурын бүлэн харваа ч энд хадгалагдаж уламжлагдсаар байна.
5. Буриадын шашин соёлын хөгжлийн түүх нь ХҮИ-ХХ зуунд өвөр Байгал болон Монголд өрнөсөн улс төрийн үйл явцтай шууд холбогддог. Гэсэн ч буриадууд тухайн үеийн улс төрийн бодлогыг дагахын зэрэгцээ бөө мөргөлийн уламжлалаа гэр орныхоо орчинд хадгалсаар иржээ. Өөрөөр хэлбэл өнөөгийн буриадуудын дунд бөө мөргөл, бурхны шашны ёс уламжлал зэрэгцэн оршиж байна.
6. Буриад нутгаас төрж гарсан нэр алдартай эрдэмтэн мэргэд, лам нар, гэгээд хутагт цөөнгүй байдаг боловч тэдний зохиож туурвисан ном бүтээл нь толь бичиг, цөөн тооны намтар, зурхай, эм эмнэлгийн бүтээлүүд байна. Буриадад шашин дэлгэрсэн түүхийн талаар өгүүлсэн чойнжүн маягийн зохиол өнөө хэр бараг үгүй гэж хэлж болохоор байна. Иймд судалгааны найдвартай баримт болох төвөд, монгол хэлээр туурвисан сурвалж бичгийг хайн цуглуулж, эмхэтгэн судалгааны эргэлтэд оруулах нь нэн даруй эхлүүлэх шаардлагатай ажил болжээ.

Эдгээр ажлыг хийхийн тул цаашид:

- Монголд буриад судлалыг тодорхой систем дэс дараатай, бодлого чиглэлтэйгээр эрдэмтэн судлаачдын хүч, боломж, бололцоог нэгтгэн чанарын шинэ шатанд гаргах нь цаг үеийн шаардлагаар бидний өмнө тавигдаж байна. Үүний тул буриад судлаачдын залуу халааг бэлтгэх, тэднийг сургаж дадлагажуулах, сэтгэл зүрхээрээ буриад судлалын ажлыг эрхлэн ажиллах залуучуудыг олж, тэднийг дэмжин туслах, эрдэм судлалын ажлын аргазүйд сургахаас гадна гадаад хэлний мэдлэг

боловсролыг дээшлүүлэх, хөрш орнуудын буриад судлаачдын туршлагаас суралцуулж, цаашдын эрдэм судлалын ажилд нь чиглүүлэх, залуу судлаачдыг дагуулан шавь сургалтын аргаар бэлтгэж, залгамж халаагаа бэлтгэхэд судлаачид дор бүрнээ анхаарч ойрын жилүүдэд гарын шавьтай болох ажлыг эрчимжүүлэх,

- Буриадын ардын язгуур урлаг, үндэсний спортыг судлах, сурталчилан дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулахдаа төрийн бодлого үйл ажиллагаатай уялдуулж ажиллах,
- Буриад-монголчуудын талаарх дэлгэрэнгүй их тайлбар толийг олон нийтийн дэмжлэг, туслалцаатайгаар хийж гүйцэтгэх,
- Буриад судлалын талаарх ном бүтээлүүдийг “Буриад судлалын номын сан” цувралын доор нэг загвар, нэг стандарттай болгон хэвлүүлж хэвших зэргээр үйл ажиллагаагаа тогтмол явуулж, эрдэм шинжилгээний бага хурал, сэтгүүлээ цаашид улам төгөлдөржүүлж, олон нийтэд буриадуудын талаар зөв бодол, хандлага төлөвшүүлэх нь чухал байна.
- Мөн гадаад харилцааг өргөжүүлэхэд анхаарч дэлхийгээр тархан суурьшсан буриадууд болон ОХУ-ын Буриад Улс, Эрхүү мужийн Усть-Орда, Өвөр Байгалийн Хязгаарын Ага, Чита, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эвенкэ хошууны Хөлөнбуйрын Шинэхээн зэрэг газрын буриад монголчуудтайгаа эрдэм шинжилгээ болон соёлын харилцаагаа улам өргөжүүлж, эрдэм шинжилгээний ажилтнуудыг сургах, харилцан солилцох, туршлагаа хуваалцах, хамтарсан эрдэм шинжилгээний экспедицийг зохион байгуулах зэрэг ажлыг хийх нь буриад судлал олон улсын төвшинд хөгжих боломж, бололцоог нээх болно.

ТАЛАРХАЛ

Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын уламжлал, хувирал” Оростой хамтарсан төслийг санхүүжүүлж, судалгаа хийх нөхцөлийг бүрдүүлж өгсөн Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яам, Шинжлэх ухаан технологийн санд төслийн баг хамт олон гүнээ талархаж байна.

Та бүхний дэмжин санхүүжүүлж, төсөл хэрэгжүүлсний үрээр цаашид буриад судлалын чиглэлээрх судалгаа, шинжилгээний ажлууд улам даацтай болж, нарийвчлан тодорхойлох сэдвүүд олон болж байгаа бөгөөд сонирхон судлаач, эрдэмтэд ч өсөн нэмэгдэж байгаад туйлын их баяртай байна. Төслийн үр дүнд ШУА-ийн холбогдох хүрээлэнгүүд, их дээд сургуулийн дэргэдэх судалгааны төвүүд, Буриад судлалын академи тэргүүтэй төрийн бус байгууллагыг ч хамруулж буриад-монголчуудын угсаа гарвал, биет болон биет бус соёлын өвүүдийн талаарх ихэд анхаарч, төсөл хэрэгжүүлж, судлагааны ажлын хамрах хүрээг тэлж байгаа нь хожмоо үр дүнтэй, сайн сайн судалгааны бүтээл туурвих хөрсийг сайтар бэлтгэж өгч байна гэж үзэж байна.

Хавсралт 1. Төслийн үр дүнд гарсан бүтээлийн жагсаалт

Ном, хөрвүүлэг -10

1. Л.Оюунцэцэг. Бэрхийг туулсан басгад. Уб., 2021
2. Л. Оюунцэцэг. Тэшиг тийш сэтгэл татагдана. Аян замын тэмдэглэл. Уб., 2019
3. Л. Оюунцэцэг. "Тоонтымни хүхэ шулуун". Шүлгийн түүвэр. Уб., 2020
4. Л. Оюунцэцэг. Гүүртэдэ. Шүлгийн түүвэр. Уб., 2020
5. Л. Оюунцэцэг. Хайрханаймни бэшэрэл. Шүлгийн түүвэр. Уб., 2020
6. Сергей Бахлаев. “Молон багш”, хөрвүүлсэн Л. Оюунцэцэг. Уб., 2021
7. “Балжин хатан”. Монгол хэлний буриад аялгаас халх аялганаа хөрвүүлсэн Л. Оюунцэцэг. Уб., 2021
8. Г. Гантогтох. “Монголой нюуса тобшоон”. редактор Л. Оюунцэцэг.
9. Дэд хурандаа Чимиддоржийн Аюуш. Хөрөг дурсамжийг Л. Оюунцэцэг.
10. Бүмбэй баряашын эди шэди. Хөрөг дурсамжийг Л. Оюунцэцэг.

Эмхэтгэл-2

1. Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралтын судалгаа. Эрхэлсэн Д.Наранцэцэг, М.Одмандах. Улаанбаатар., 2022
2. Буриад судлал. Боть-11. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Эмхэтгэсэн М.Одмандах, Л.Оюунцэцэг. Редактор Д.Наранцэцэг. Улаанбаатар., 2022

Тайлан-1

1. "Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралтын судалгаа" төслийн тайлан. Уб., 2022

Эрдэм шинжилгээний өгүүдэл -23

Гадаадад -10

1. Наранцэцэг Д., Дампилова Л.,С. Мифологические мотивы в легендах и реданиях о Чингисхане //Республике Бурятия-95 лет: сб. науч. ст. -Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2018. -с 279-281
2. Бураева, О. В., Наранцэцэг Д. Русские в Монголии: свидетельство А. И. Маслова //Современная научная мысль. М., 2019. №6, с167-176

3. Наранцэцэг Д. *Монгольские буддийские обряды и церемоний*. // Миряне и ламы: Буддийские идеи и практики в трансформирующихся обществах России и Монголии. Ответственный редактор д-р, ист. наук, проф. Л. Л. Абаева. Улан-Удэ: изд-во БНЦ СО РАН, 2019. стр 284-289
4. Л. С. Дампилова, Д. Наранцэцэг. Символический язык шаманских песнопений бурят России и Монголии. DOI 10.25882/xgfb-hb63.//Mongolica, Vol. XXIII, Saint Peterburg, 2020,
5. Сундуева Е. В., Одмандах М. “Этнокультурные связи Русских и Бурят в Монголии” өгүүлийг бичиж “Манускрипт” олон улсын цахим сэтгүүлийн 2019 оны Том 12. Выпуск 10-рт /С. 108-112. ISSN 2618-9690/, <http://www.gramota.net/materials/9/2019/10/20.html>
6. Цыбикова Б. Б., Одмандах М. “Мифологический пласт в устных произведениях несказочной прозы бурят”. //Бурятия-95, Улан-Удэ., 2018, стр. 282-283
7. Жамсуева Д. С., Оюунцэцэг Л. “Цугольский и шэнэхэнский дацаны в сравнительном аспекте” *ВЛАСТЬ Общациональный научно-политический журнал. Улан-Удэ 2018., №09. Т. 28. Стр 212-219*
8. Жамсуева Д., Оюунцэцэг Л. Ритуальные аспекты мистерии Цам в бурятских дацанах. *Власть //Общациональный научно-политический журнал. №3 /27/ Улан-уде. 2019., стр189-193*
9. Сундуева Е. В., Баттуяа О. “Мотивы номинации в топонимии Кяхтинского района Республики Бурятия. //Найдаковские чтения-4 Тюрко-Монгольский мир, гуманитарные исследования, Изд БНЦ СО РАН Улан-Удэ-2018
10. Цыбикова, Б. Б., Баттуяа О. Сохранение родного языка в полиэтнических общностях (анализ опыта бурят Внутренней Монголии Китая). //Языки в полиэтническом государстве развитие, планирование, прогнозирование. Улан-Удэ, 2019, стр 205-207

Дотоодод-13

11. Д. Наранцэцэг. Буриад лам нарын намтар зохиолоор Буриадад шашин дэлгэрсэн түүхийг нөхвөрлөх нь. //Төвд судлал. Уб., 2018. Боть 7, Дэвтэр 8. 158-180-р талд
12. Наранцэцэг Д., Сундуева Е., В. Буриадын эрдэмтэй лам Галсанжамбын орчуулсан "Бурхан багшийн намтар" зохиолын эх бичгийн шинжлэл. //Шинжлэх ухааны академийн хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бичиг. Төвд судлал. Уб., 2019. Том 8. Fasc 8. 111-118-р тал
13. Наранцэцэг Д. Сундуева Е., В *Шинэхээн Буриадын мэнгэ андалдах зан үйлийн өнөөгийн байдал*. //Монголын соёл урлаг судлал. Уб., 2020. Том XXXV, Fasc 5. 53-61-р тал
14. Наранцэцэг Д., Дампилова Л.,С. Орос, Монгол, Хятад гурван улсын буриад угсаатны аман зохиол, аман соёл, угсаатны соёлын хамгаалалт, хувиралт. //Монголын соёл урлаг судлал. Уб., 2020. Том XXXIX, Fasc 8. 88-96-р тал
15. Баярчимэг Э., Наранцэцэг Д. Буриад аялгууны үгийн сангийн зарим онцлогоос. //Буриад судлал сэтгүүл, 2022, Том 11, Fasc 8, 61-75
16. М. Одмандах. Булган аймгийн Тэшиг сумын буриадын уламжлалт соёлын хувиралт, хадгалалт. МУБИС-ийн “Монгол судлалын чуулган”, Уб., 2019, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдсэн. №59.

17. М. Одмандах. Буриадын үндэсний наадам, спортын хувиралт, өөрчлөлт, өнөөгийн байдал. //Буриад судлал сэтгүүл, 2022, Том 11, Fasc 10, 86-107
18. Оюунцэцэг Л., Жамсуева Д. С. “Хууяа шилэ” дууны өгүүлэмжээс угсаатны соёлыг олж сонордохуй. //Монголын соёл урлаг судлал. Уб., 2018. Том XXIX. Fasc 24. 218-233-р тал
19. Оюунцэцэг Л., Бадамханда Ц. Б. Өүлэн үжиний "шивэргэл" гэзгийг буриад эхнэрийн "шибэргэл" гэзэгтэй харьцуулан үзэж, археологийн олдвороор мөшгин тодруулах нь. //Монголын соёл урлаг судлал. Уб., 2019. Том XXXIII. Fasc 3. 27-39-р тал
20. Л. Оюунцэцэг. “Соёлын өв: Тэшигийн буриадуудын үндэсний хувцасны хадгалалт, хувиралт”. //Буриад судлал сэтгүүл, 2022, Том 11, Fasc 11, 108-124
21. Баттуяа О., Цыбикова Б. Б. Буриадын шашин мөргөлийн уламжлалын асуудалд //Монголын соёл урлаг судлал. Уб., 2018. Том XXIX. Fasc 5. 58-66-р тал
22. Баттуяа О, Жамсуева Д. С. Оросын нөлөөн доорх буриадуудын газар эзэмшил ба угсаатны үйл явц. //Монголын соёл урлаг судлал. Уб., 2019. Том XXXIII. Fasc 5. 47-54-р тал
23. Баттуяа О. 20-р зууны Монголын угсаатны хөгжлийн явц дахь буриад, хамниган. //Буриад судлал сэтгүүл, 2022, Том 11, Fasc 3, 24-30

Судалгааны илтгэл-14

Гадаадад-4

1. Баттуяа О. Монголын хамниганы хэл аялгуу. -ОХУ-ын Буриадын Их сургуулийн профессор Цей жаб Цыдыповын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал "Языки и литературы монгольских народов: теория и практика"-д хэлэлцүүлсэн илтгэл. Улан-удэ. 2019.10-24
2. Наранцэцэг Д. Буриадын эрдэмтэй лам Галсанжамбын орчуулсан “Бурхан багшийн намтар” зохиолын тухай. “Бичгийн өв ба монголчуудын түүх соёлын чухал асуудлууд” олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. ОХУ, Улан-Үдэ. 2017.09.08
3. Одмандах М. “Монголын буриадын нүүдэл, суурьшил”. -Япон улсын Шова их сургуульд болсон “XX зууны монголын ертөнц: эргэн харах нь” олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. 2018.11.06
4. Оюунцэцэг Л. Буриад судлалын академийн үүсэл, хөгжил. -ОХУ-ын Буриадын Их сургуулийн профессор Цей жаб Цыдыповын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал "Языки и литературы монгольских народов: теория и практика"-д хэлэлцүүлсэн илтгэл. Улан-удэ. 2019.10-24

Дотоодод-10

5. Баттуяа О. 20-р зууны Монголын угсаатны хөгжлийн явц дахь буриад, хамниган. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Буриад судлалын академи хамтран зохион байгуулсан "Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралт" олон улсын хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Улаанбаатар. 2022.04.02

6. Баярчимэг Э., Наранцэцэг Д. Буриад аялгууны үгийн сангийн зарим онцлогоос. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Буриад судлалын академи хамтран зохион байгуулсан "Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралт" олон улсын хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Улаанбаатар. 2022.04.02
7. Л. Оюунцэцэг. “Соёлын өв: Тэшигийн буриадуудын үндэсний хувцасны хадгалалт, хувиралт”. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Буриад судлалын академи хамтран зохион байгуулсан "Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралт" олон улсын хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Улаанбаатар. 2022.04.02
8. М. Одмандах. “Батын Нямаагийн “Арандалынхан” роман дахь буриадын тухай дүрслэл, түүний онцлог” илтгэлийг профессор Саян Жимбеевич Балдановын 85 насны ойд зориулан ОХУ-ын Буриад улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, Дорж Банзаровын нэрэмжит БУИС, Дорно дахины дээд сургууль, Буриад хэл, уран зохиолын сургууль, Буриад, эвэнк хэлний тэнхимийн хамтран зохион байгуулсан “Сибирь – ардын аман зохиол ба уран зохиолын үндэстний орон зай” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хурал. 2020 оны 12-р сарын 10-11.
9. М. Одмандах. “Гончигдамбын Дарамзагдын уг гарвал” илтгэлийг Монголын хөгжмийн нэрт зохиолч, найрал дууны удирдаач Гончигдамбын 90 жилийн ойд зориулсан “Г.Дарамзагд амьдрал, уран бүтээл судлал-2021” эрдэм шинжилгээний бага хурал. 2021 оны 11-р сарын 24-ны өдөр. Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга, Офицеруудын ордон, Соёмбо танхим.
10. М. Одмандах. “Ж.Цэвээн ба Шинэ толь хэмээх бичиг сонины түүхийн үнэнийг тодруулах асуудалд”. Их соён гэгээрүүлэгч Шарайд Жамсраны Цэвээний мэндлэсний 140 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн эрдэм шинжилгээний хурал. Их засаг олон улсын их сургууль, 2021.10.16.
11. М. Одмандах. Буриадын үндэсний наадам, спортын хувиралт, өөрчлөлт, өнөөгийн байдал. . ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Буриад судлалын академи хамтран зохион байгуулсан "Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, угсаатны соёлын хадгалалт, хувиралт" олон улсын хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Улаанбаатар.
12. М. Одмандах. Улз голын буриадууд. Буриад судлалын академи, Д.Жаргалсайхан сан, Монгол улсын Консерваторийн хамтран зохион байгуулсан “Дэлхийд танигдсан дуучин-Д.Жаргалсайхан 80” гэсэн эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. УБ хот. 2019.03.22
13. Наранцэцэг Д. Сундуева Е. В. Буриадад шашин дэлгэрсэн түүхийг буриад лам нарын намтар зохиолоор нөхвөрлөх нь. -*МУИС-аас зохион байгуулсан “Буддизм ба тогтвортой хөгжил” олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. 2018.11.02*
14. Наранцэцэг Д., Дампилова Л.,С. Орос, Монгол, Хятад гурван улсын буриад угсаатны аман зохиол, аман соёл, угсаатны соёлын хамгаалалт, хувиралт. Соёл урлаг судлалын хүрээлэнгийн 45 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Улаанбаатар, 2020.02.24

Хавсралт 2. Эрдмийн зөвлөлийн тогтоол, хурлын протокол



СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ
СОЁЛ УРЛАГ СУДЛАЛЫН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Төслийн үр дүнг хүлээн авах тухай

Шинжлэх ухааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дох заалт, 23 дугаар зүйлийн 23.1. дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус хүрээлэнд 2018 оноос хэрэгжиж байгаа “Орос Монгол Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, хадгалалт хувиралтын судалгаа” сэдэвт хамтарсан төслийн үр дүнг хүлээн авсугай.

2. Төслийн үр дүнгээр хэвлэгдсэн бүтээл, компьютер техник хэрэгслийг хүлээн авч, санхүүгийн тооцоо дуусгахыг нягтлан бодогч /Н.Оюумаа/-д, төслийн тайлан, холбогдох бичиг баримтыг Шинжлэх ухаан технологийн санд хүлээлгэн өгөхийг төслийн удирдагч /Д.Наранцэцэг/-т даалгасугай.

ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.АЛТАНЦЭЦЭГ

СУИС-ИЙН СОЁЛ, УРЛАГ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

№4

2022 оны 5 дугаар сарын 25

Хурал: СУИС-ийн хичээлийн I байрны 4 давхарт, Ахисан түвшний номын санд 14:00-15:30 цагт болов.

Хуралд: Эрдмийн зөвлөлийн дарга доктор (Sc.D), профессор Ч.Алтанцэцэг, Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ph.D), дэд профессор Б.Мөнхцэцэг, эрдмийн зөвлөлийн гишүүн доктор Sc.D), профессор С.Дулам, Ж.Цэзэн, доктор (Ph.D) Ж.Баянсан, С.Соронзонболд, Ц.Энхчимэг, Д.Уранчимэг, М.Золзаяа, Ц.Цэвэгсүрэн, Д.Мэндсайхан, Ж.Мяндас, Д.Энхцэцэг нар оролцов.

Хэлэлцэх асуудал: Соёл урлаг судлалын хүрээлэнд хэрэгжиж байгаа Орос Монголын хамтарсан “Орос Монгол Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, хадгалалт хувиралтын судалгаа” төслийн үр дүнгийн тухай

Хэлэлцсэн нь:

Хурлыг эрдмийн зөвлөлийн дарга Ч.Алтанцэцэг удирдав.

доктор (Sc.D), профессор Ч. Алтанцэцэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр манай хүрээлэн дээр 2018 оноос хэрэгжиж байгаа “Орос Монгол Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, хадгалалт хувиралтын судалгаа” гэсэн хамтарсан төслийн үр дүнг хүлээлгэж өгөх асуудлаар эрдмийн зөвлөлийн гишүүд та бүхнийг дуудан хуралдуулж байна. Ингээд төслийн удирдагч доктор (Ph.D), профессор Д.Наранцэцэг танилцуулна.

Д.Наранцэцэг:

Бидний хэрэгжүүлсэн төслийн гол зорилго бол Орос, Монгол, Хятад энэ гурван улсад амьдран суудаг буриад угсаатнуудын аман соёлын үндсэн эхүүд хэрхэн хадгалагдаж ирсэн байдал болон одоо ямар болж хувиран өөрчлөгдсөнийг харьцуулсан судалж гаргах, тэр дундаа буриадуудын буддын болон бөө мөргөлийн аман соёл, ёс уламжлалыг угсаатны зүйн талаас нь судалж, угсаатны цөөнх гэж хэлж болох буриадын соёл уламжлалыг хадгалахад чиглэгдэж байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол манай төслийн гол үйл ажиллагаа “Орос, Монгол, Хятад гурван улсын буриад угсаатны аман зохиол, аман соёл, угсаатны соёлын уламжлал, хувирал”-ыг судлахад чиглэсэн. Тэгээд ингэхийн тулд энэ талаар өмнө үеийн судлаачдын хийсэн судалгаа шинжилгээний ажил, архивын баримт материалыг үзэж харах, судалгааны багийн гишүүд өөрсдөө орон нутагт судлан байцаах ажлыг шинээр биечлэн хийж, хуучин баримтыг магадлах эрдэм шинжилгээний ажлыг ОХУ, БНХАУ, Монгол улсын буриад угсаатан төвлөрөн суурьшсан нутгаар явж хийх төлөвлөгөө гаргаж батлуулсан. Энэ төслийн үр дүнд буриад угсаатны түүх, аман соёл, угсаатан зүйн шинэ эх

хэрэглэгдэхүүнийг аль чадахаар сурвалжлан цуглуулж, судалгааны эргэлтэнд оруулан олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал хийх, эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх зэрэг ажлыг дэс дараатай хийж, хугацааны эцэст энэ бүгдийгээ нийлүүлэн хамтын зохиогчтой “Орос, Монгол, Хятадын буриад угсаатны аман соёл угсаатны зүйн хүчин зүйл болох нь” хэмээх эмхэтгэл бичиж бэлэн болгоно гэсэн зорилгоор ШУТС-тай гэрээ байгуулж, төслөө эхлүүлсэн.

Тэгээд энэ зорилгоо биелүүлэхийн тулд өмнөх судлаачдын хийсэн судалгааны ажлуудтай нэгбүрчлэн танилцах, өөрсдөө гурван улсын буриадын нутгаар явж, өнөөгийн байдалтай биечлэн танилцах зорилт тавьж ажилласан. Өмнө нь ямар байсан бэ гэдгийг ахмад судлаачдын 1960-аад оноос эхлээд хээрийн шинжилгээний ангиар явж цуглуулсан судалгааны эх хэрэглэгдэхүүн, тайлан, бусад материал болон өөрсдийн хийсэн ярилцлагыг гол болгон ашиглаж үнэлэлт дүгнэлт өгөх замаар ийм байжээ гэж тогтоосон. Тэгээд өөрсдөө хэд хэдэн удаа 3 улсын буриадуудын дунд томилолтоор ажиллаж, одоогийн байдлыг тогтоосон. Тухайлах юм бол Оросын буриадад миний бие 1 удаа, доктор Оюунцэцэг, Баттуяа нар 1 удаа, Хятадын буриадад Одмандах бид 2 хоёр сарын хугацаагаар ажилласан. Монголынхоо буриад нутгаар Булганы Тэшиг суманд Одмандах, Оюунцэцэг нар 7 хоногийн хугацаагаар, доктор Баттуяа хагас сар явж судалсан. Дээрээс нь манай төслийн багийн гишүүд өөрсдөө буриад хүмүүс, төрөхөөсөө аваад өдийг хүртэл буриад нутагт амьдарсан, одоо болтол нутаг усныхантайгаа байнгын холбоотой явж ирсэн, өөрсдөө буриад ёс уламжлалаа сайн мэддэг, үүнийгээ түгээн дэлгэрүүлэх, уламжилж хадгалахыг хичээж явдаг нь энэ төслийг хэрэгжүүлэхэд бас маш том түлхэц, тус нэмэр болсон л доо. За тэгээд бид түрүүн хэлсэн өмнөх үеийн судалгааг өөрсдийнхөө явж ажиглаж, тэмдэглэж авсан одоогийн байдалтай нь харьцуулах замаар уламжлалаа хадгалж байна уу, эсвэл өөрчлөгдөн хувирчихсан байна уу гэдгийг гаргасан.

Судалгааны явцад ОХУ, БНХАУ, Монгол гэсэн гурван гүрэнд тасран суусан буриадуудыг угсаатны томоохон бүлэглэл болохынх нь хувьд тэдний түүх, угсаатан, ёс заншил, аман зохиол, хэл соёл, утга урлаг, эдийн соёл зэргийг бүгдийг нь хамарсан цогц судалгаа зайлшгүй хийх шаардлагатай юм байна аа гэж ярилцаад, хэдүүлээ чиглэл чиглэлээр нь хувааж аваад, тал бүрээс нь ажигласан л даа. Ингээд дараах дүгнэлтэд хүрээд байна.

2. Монгол улсад суугаа буриадуудын уламжлал, соёл нь цагийн эрхээр хувирч байгаа хэдий боловч сүүлийн 30 орчим жилд сэргээх, хөгжүүлэх, хадгалах гэж тал талдаа анхаардаг болжээ. Үүний нэг жишээ нь Монгол Улсаас эхлэн өнөөдөр олон улсын хэмжээнд зохиогдох болсон Алтаргана наадам юм байна. Энэ наадам хийх болсноор буриадуудын ухамсар сэтгэлгээнд уламжлалт соёлоо гэсэн хандлага бий болж, улмаар үгүй болох эрсдэлтэй соёл, уламжлалаа сэргээх, хадгалах үзэгдэл нийт буриадын дунд эрчимжсэн тал ажиглагдаж байна. Тухайлбал, Булган аймгийн Тэшиг суманд болсон “Бага Алтаргана-2019” наадмын үеэр хийсэн гүймэг судалгаанд тулгуурлан соёлын хувиралт, хадгалалтын ярихад уламжлалт заншил, хэв ёсоо нэлээн гээж, орчин нөхцөлдөө уусан шингэж илүү халхжуу болсон байна. Тэд буриад гэдгээ ойлгож, мэдэрч, өөрсдийгөө таниж мэдэх гэж хичээж байгаа нь “Бага Алтаргана” наадмыг анх удаагаа орон нутагтаа зохион байгуулсан явдлаас харагдаж байна гэж хэлж болмоор санагдаж байгаа юм. Тэшиг сумын буриадууд дээл хувцас, эдлэл хэрэглэлийн

хувьд уламжлалт хэв загвараа гээсэн тул одоо цагийн Дорнод аймгийн Ага буриадын дээл, гоёлыг шууд хуулбарлан хэрэглэх болсон байна. Энэ нь нэг талаас буриад гэдгээ мэдрэх, олонд танигдсан энгэртэй дээлийг авсан мэт боловч нөгөө талаар өөрсдийн язгуурын дээл хувцасаа сэргээж хэрэглэхгүй байх үндэс болж байна. Иймд аль алийг нь хэрэглэж, дэлгэрүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

7. ОХУ-ын буриадууд буриад хэл аялгаараа төдий л өөр хоорондоо ярьдаггүйгээс эх хэл, соёл уламжлалдаа бахтай эрдэмтэн сэхээтэн зэрэг цөөн хүмүүсийн дунд л буриад хэл аялгуу уламжлан үлджээ. Гэвч сүүлийн жилүүдэд мөн л буриад хэл аялгуугаа сэргээх, уламжлуулах олон арга хэмжээ зохиож байгаа нь сайшаалтай бөгөөд үүнийг цаашид тасралтгүй эрчимжүүлж гэмээнэ сая өөрсдийн хэл аялгаа хадгалж, хамгаалж авч үлдэж чадна гэж бодож байна.
8. БНХАУ-ын буриадууд хэл аялгаа нэлээн хадгалсан, гэр зуураа буриад аялгаараа ярьдаг, монгол дунд сургуульд ч буриад хэлний хичээл 2019-2020 оны хичээлийн жил болтол орж байсан нь буриад аялгаа хадгалахад чухал ач холбогдолтой байна. Тэд хэдийгээр тооны хувьд харьцангуй цөөн хүн амтай боловч буриад үг хэллэг, хувцас хэрэглэл, угийн бичиг, овог аймаг, эцэг эхийн удам судрын нэрээ марталгүй хадгалж ирсэн, буриадын тоонот тайх зан үйл, мэнгэ андалдах ёс уламжлал, буриад сурын бүлэн харваа ч энд хадгалагдаж уламжлагдсаар байна.
9. Буриадын шашин соёлын хөгжлийн түүх нь ХҮИ-ХХ зуунд өвөр Байгал болон Монголд өрнөсөн улс төрийн үйл явцтай шууд холбогддог. Гэсэн ч буриадууд тухайн үеийн улс төрийн бодлогыг дагахын зэрэгцээ бөө мөргөлийн уламжлалаа гэр орныхоо орчинд хадгалсаар иржээ. Өөрөөр хэлбэл өнөөгийн буриадуудын дунд бөө мөргөл, бурхны шашны ёс уламжлал зэрэгцэн оршиж байна.
10. Буриад нутгаас төрж гарсан нэр алдартай эрдэмтэн мэргэд, лам нар, гэгээд хутагт цөөнгүй байдаг боловч тэдний зохиож туурвисан ном бүтээл нь толь бичиг, цөөн тооны намтар, зурхай, эм эмнэлгийн бүтээлүүд байна. Буриадад шашин дэлгэрсэн түүхийн талаар өгүүлсэн чойнжүн маягийн зохиол өнөө хэр бараг үгүй гэж хэлж болохоор байна. Иймд судалгааны найдвартай баримт болох төвөд, монгол хэлээр туурвисан сурвалж бичгийг хайн цуглуулж, эмхэтгэн судалгааны эргэлтэд оруулах нь нэн даруй эхлүүлэх шаардлагатай ажил болжээ.

Эдгээр ажлыг хийхийн тул цаашид:

- Монголд буриад судлалыг тодорхой систем дэс дараатай, бодлого чиглэлтэйгээр эрдэмтэн судлаачдын хүч, боломж, бололцоог нэгтгэн чанарын шинэ шатанд гаргах нь цаг үеийн шаардлагаар бидний өмнө тавигдаж байна. Үүний тул буриад судлаачдын залуу халааг бэлтгэх, тэднийг сургаж дадлагажуулах, сэтгэл зүрхээрээ буриад судлалын ажлыг эрхлэн ажиллах залуучуудыг олж, тэднийг дэмжин туслах, эрдэм судлалын ажлын аргазүйд сургахаас гадна гадаад хэлний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хөрш орнуудын буриад судлаачдын туршлагаас суралцуулж, цаашдын эрдэм судлалын ажилд нь чиглүүлэх, залуу судлаачдыг дагуулан шавь сургалтын аргаар бэлтгэж, залгамж халаагаа бэлтгэхэд судлаачид дор бүрнээ анхаарч ойрын жилүүдэд гарын шавьтай болох ажлыг эрчимжүүлэх,
- Буриадын ардын язгуур урлаг, үндэсний спортыг судлах, сурталчилан дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулахдаа төрийн бодлого үйл ажиллагаатай уялдуулж ажиллах,

- Буриад-монголчуудын талаарх дэлгэрэнгүй их тайлбар толийг олон нийтийн дэмжлэг, туслалцаатайгаар хийж гүйцэтгэх,
- Буриад судлалын талаарх ном бүтээлүүдийг “Буриад судлалын номын сан” цувралын доор нэг загвар, нэг стандарттай болгон хэвлүүлж хэвших зэргээр үйл ажиллагаагаа тогтмол явуулж, эрдэм шинжилгээний бага хурал, сэтгүүлээ цаашид улам төгөлдөржүүлж, олон нийтэд буриадчуудын талаар зөв бодол, хандлага төлөвшүүлэх нь чухал байна.
- Мөн гадаад харилцааг өргөжүүлэхэд анхаарч дэлхийгээр тархан суурьшсан буриадчууд болон ОХУ-ын Буриад Улс, Эрхүү мужийн Усть-Орда, Өвөр Байгалийн Хязгаарын Ага, Чита, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эвенк хошууны Хөлөнбуйрын Шинэхээн зэрэг газрын буриад монголчуудтайгаа эрдэм шинжилгээ болон соёлын харилцаагаа улам өргөжүүлж, эрдэм шинжилгээний ажилтнуудыг сургах, харилцан солилцох, туршлагаа хуваалцах, хамтарсан эрдэм шинжилгээний экспедицийг зохион байгуулах зэрэг ажлыг хийх нь буриад судлал олон улсын төвшинд хөгжих боломж, бололцоог нээх байх гэсэн дүгнэлт саналд бид нэгдсэн.

Гэхдээ мэдээж бидний томилолтын зардал бага, цаг хугацааны давчуу байдал, бусад хүчин зүйл, ялангуяа энэ дэлхий нийтийг хамарсан цар тахлын цаг үеийн байдал зэргээс болоод өөрсдийн бодож төсөөлж байсан шигээ нарийн дэлгэрэнгүй судалгаа хийж чадаагүй, тодорхой бодитой үр дүнд хүрч чадаагүй тал бол байгаа.

Гэвч бидний байгуулсан гэрээнд төслийн үр дүнгийн даалгавар юу байсан гэхээр хийсэн судалгааныхаа дагуу Оросын талын эрдэмтэдтэй хамтран эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, дотоод гадаад хэвлүүлэх, Буриад судлалын академитай хамтран олон улсын эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, өгүүллийн эмхэтгэлийг хэвлүүлэх гэсэн шаардлага байсан. Үүнийгээ бол бүрэн биелүүлсэн.

доктор (Sc.D), профессор Ж.Цээн: Төслийн ажлын талаар ойлголоо. Сайн ажил хийсэн байна. Би энэ хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн гишүүнээр нэлээн хэдэн жил ажиллаж байна. Анх ийм төслийн санал мэдүүлж байна гэдгийг л нэг удаа эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Тэгээд төсөл нь батлагдаагүй юм байна гэж бодож байлаа. Тэгсэн овоо ажил хийчихсэн, үр дүн нь хэвлэгдчихсэн юм байна. Одоо тайлангаа сайн бичээд өгчихвөл боллоо гэж ойлголоо. Дэмжиж байна.

доктор (Ph.D), профессор Ц.Энхчимэг: Нараа танай энэ хийсэн ажлууд яг анх байгуулсан гэрээнд заасан үр дүнгийн даалгавартайгаа таарч байгаа юу. Өгүүлэл, илтгэл 8, 8 гэсэн байна. Энэ бүрэн гарсан уу?

доктор (Ph.D), профессор Д.Наранцэцэг: 2 эмхэтгэл, 16 илтгэл өгүүлэл гэж үр дүнгийн даалгаварт байгаа. Бид 2 эмхэтгэл, 30 гаруй илтгэл өгүүлэл бичиж хэвлүүлсэн.

доктор (Ph.D), дэд профессор Б.Мөнхцэцэг: Ажлаа бол төслийн гэрээний үр дүнгийн даалгаврын дагуу гүйцэтгэсэн байна. Харин нэг юм сонирхож асууя. Энд Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн нэг ч хүн байхгүй байж, яагаад хүрээлэн дээр хэрэгжиж байгаа юм

доктор (Ph.D), профессор Д.Наранцэцэг: Энэ ийм юм. Би 2018 онд хүрээлэнд Эрдэмтэн нарийн бичгийн дарга байсан, доктор О.Баттуяа Соёл судлалын салбарын

эрхлэгч байсан. Тэр үедээ мэдүүлж авсан төсөл юм. Манай төслийн багийнхан яг энэ чиглэлээр мэргэжсэн, судалгаа хийсэн хүмүүс учраас багийн гишүүд солигдоогүй юм.

доктор (Sc.D), профессор С.Дулам: Их сонирхолтой сайн судалгаа хийж, үр дүн нь ч гарчээ. Дэмжиж, хүлээн авах саналтай байна.

доктор (Sc.D), профессор Ч.Алтанцэцэг: За би бас дэмжиж байна. Өөр асуулт саналгүй бол энэ төслийг хүлээж авах саналтай гишүүд гараа өргөх үү?

Бүгд дэмжиж, гар өргөв.

доктор (Sc.D), профессор Ч.Алтанцэцэг: Эрдмийн зөвлөлийн гишүүд бүгд дэмжлээ. Соёл, урлаг судлалын хүрээлэнгээс нэр дэвшүүлж, дэмжигдэн 2018 оноос хэрэгжүүлсэн Орос, Монголын хамтарсан төслийг амжилттай удирдаж үр дүнг бүрэн хангасан тул төслийг хүлээн авахыг эрдмийн зөвлөлийн гишүүд бүрэн дэмжсэн тул холбогдох тогтоолыг гаргахаар шийдвэрлэв. Тогтоолын төслийг уншиж сонсгов. Гишүүд дэмжив.

Шийдвэрлэсэн нь:

“Монгол, Орос, Хятад гурван улсын буриад угсаатны аман соёл, хадгалалт хувиралтын судалгаа” сэдэвт хамтарсан төслийн үр дүнг хүлээж авахыг дэмжив.

Протокол хөтөлсөн:

Протокол хянасан:

Оффис менежер Б.Буяннэмэх

Захирал Ч.Алтанцэцэг

Хавсралт 3. ОХУ-ын төсөл хамтран гүйцэтгэгч байгууллагын тодорхойлолт

МИНОБРНАУКИ РОССИИ

**ФЕДЕРАЛЬНОЕ ГОСУДАРСТВЕННОЕ
БЮДЖЕТНОЕ УЧРЕЖДЕНИЕ НАУКИ
ИНСТИТУТ МОНГОЛОВЕДЕНИЯ,
БУДДОЛОГИИ И ТИБЕТОЛОГИИ
СИБИРСКОГО ОТДЕЛЕНИЯ
РОССИЙСКОЙ АКАДЕМИИ НАУК
(ИМБТ СО РАН)**

ОКПО: 5160346

ОГРН: 1020300902368

ИНН 0323039823 /КПП 032301001

670047, г. Улан-Удэ, ул. Сахьяновой, 6

тел./fax: (3012) 43-35-51

e-mail: imbt@imbt.ru


№ 5 05.2022 № 242 05/33-219

На № _____

Министерству образования,
культуры и науки Монголии

Настоящим письмом подтверждаем, что в 2018–2020 гг. сотрудниками нашего Института проводился совместный проект РФФИ–МинОКН Монголии №18-512-94003 «Сохранность и трансформация фольклорных и этнокультурных традиций бурят России, Монголии и Китая» под руководством д.ф.н., г.н.с. отдела литературоведения и фольклористики Л.С. Дампиловой. Руководитель с монгольской стороны – PhD Дамбийхорлоо Наранцэцэг.

Ученый секретарь Института,
к.ф.н.



Г.Н. Чимитдоржиева